

БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАНГИЙН ТӨСӨЛ

“Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт”

Аймгийн торгуулийн орлогын ногдуулалтын хэмжээ, хугацаа хэтрэлт, төлөлтийн явцад нэгдсэн хяналт тавих тогтолцоо бүрэн бүрдээгүйгээс 2023-2024 онуудад ногдуулсан торгуулийн орлогоос 819.2 сая төгрөгийн орлого дутуу төвлөрсөнөөр илэрхийлэгдэж байна.

АУДИТЫН КОД: БУА-2025/27-4-ШТА-ГА

БУЛГАН АЙМАГ
2025 ОН

Булган дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор Д.Батцогт
Утас: 7034-2580 Цахим хаяг: Battsogtd@audit.gov.mn
Аудитын менежер: Ж.Энхцоодол
Утас: 7034-2716 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn
Ахлах аудитор: П.Мөнхтуяа
Утас: 7034-2716 Цахим хаяг: Monkhtuyar@audit.gov.mn
Ахлах аудитор: П.Содном
Утас: 7034-2716 Цахим хаяг: Sodnomp@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу. bulgan@audit.gov.mn

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар	5
Хүснэгтийн товъёог	6
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл	7-8
А. ХҮҮ, ТОРГУУЛИЙН ОРЛОГЫГ БОДИТОЙ ТӨЛӨВЛӨХ, УРЬДЧИЛАН ТООЦОХ БОЛОМЖГҮЙ БАЙНА	9
A.1.1. Хүүгийн орлогод зээлийн хүүд төлөх өр төлбөрийг төлөвлөсөн байна.....	9
A.1.2. Торгуулийн орлогыг төсвийн бүрэлдэхүүн, хуульд заасан үндэслэл, шаардлагын дагуу төлөвлөж байна.....	10
A.2. Хүү, торгуулийн орлогыг гүйцэтгэлд үндэслэн төлөвлөсөн байна	10
A.2.1. Торгуулийн орлого нь сүүлийн 3 жилд 125.9-143.5 хувиар давж биелсэн байна.	10-11
A.2.2 Торгуулийн орлогыг төлөвлөхдөө орлого бүрдүүлдэг байгууллагуудын зөрчлийн тоо хэмжээ, хэрэгжилт зэрэг суурь судалгаа мэдээлэл, дүн шинжилгээг хийгээгүй байна.....	11-12
A.2.3. <i>Хүүгийн орлогыг зээлийн гэрээнд заасан хувь хэмжээгээр тооцон төлөвлөж байна</i>	12-13
A.2.4. Авто замын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2.4 дэх заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.....	13
A.2.5. Хүү, торгуулийн орлогын гүйцэтгэлд дүн шинжилгээ хийж, нэг удаагийн тогтмол бус орлогыг тодорхойлж, орлогын нөхцөл байдлыг судлах шаардлагатай байна.	13-14
A.2.6. Эх үүсвэрийг зөвхөн өмнөх оны орлогын гүйцэтгэлд үндэслэн төлөвлөсөн байна.....	14
A.3. ХҮҮ, ТОРГУУЛИЙН ОРЛОГОТӨЙ ХОЛБООТӨЙ ЗАРИМ ХУУЛИЙН ЗААЛТУУД ХООРОНДОО НИЙЦЭХГҮЙ БАЙНА	14
A.3.1. <i>Хүү, торгуулийн орлого бүрдүүлэлтийн хууль, эрх зүйн орчин нь бодит хэрэгцээ шаардлагыг хангахаар хуульчлагдсан ч зарим тохиолдолд хоорондоо уялдахгүй байна</i>	14
A.3.2. <i>Хүү бодох аргачлал, хугацаа, хүүгийн хувь хэмжээ тодорхой хуульчлагдсан байна</i>	15
A.3.3. <i>Хуулийн зарим нэг заалтууд нь хоорондоо уялдаагүй байна</i>	15
A.3.4. <i>Торгуулийн хэмжээ нь үйлдсэн зөрчилтэй нь нийцэж байна</i>	15-16
A.3.5. <i>Хууль хэрэглээ нь бүх нийтэд хуульд заасан хувь хэмжээгээр торгууль тогтоож байгаа ч торгуулийг 50 хувиар хөнгөлөх заалт хэрэгжсэнээр иргэд, хуулийн этгээдэд эергээр нөлөөлж байна</i>	16
A.3.6. <i>Орлого бүрдүүлэлтийн эрх зүй болон ашиглаж буй системд шинэчлэл, сайжруулалт хийх хэрэгцээ шаардлага үүсэж байна</i>	16-17
A.3.7. <i>Хүү, торгуулийн орлого нь иргэний өмчийн халдашгүй байдалтай зөрчилдөөгүй байна</i>	17

Б. ХҮҮ, ТОРГУУЛИЙН ОРЛОГО БҮРДҮҮЛЭЛТИЙГ ХУУЛЬ, ЖУРАМД НИЙЦҮҮЛЭН АЖИЛЛАСАН Ч 2023-2024 ОНУУДЫН НОГДУУЛСАН ТОРГУУЛИЙН ОРЛОГООС 819.2 САЯ ТӨГРӨГИЙН ҮЛДЭГДЭЛТЭЙ БАЙНА.....17

Б.1. Торгуулийн орлогын гүйцэтгэл 2023 онд 458.9, 2024 онд 398.6 сая төгрөгөөр илүү орлого төвлөрсөн нь хугацаандаа торгуулиа төлөөгүйгээс торгууль нэмэгдэж төлөгдсөн, мөн өмнөх оны үлдэгдэл төвлөрсөнтэй холбон үзэж байна.....17

Б.1.1. Хууль, журмын дагуу тогтоож ногдуулсан торгуулийн орлогыг төсөвт 2023 онд 85.7, 2024 онд 69.4 хувийн биелэлтэй гарчээ.....17

Б.1.2. Торгуулийг эрх бүхий байгууллага, албан тушаалтан бичиж хүргүүлсэн байна.....17

Б.1.3. Орлого бүрдүүлэлтийг аймгийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аймгийн төсвийн орлогын дансанд төвлөрсөн гүйцэтгэлийн дүнгээр тайлагнасан байна.....18-19

Б.1.4. Хүү, торгуулийн орлого бүрдүүлэлт нь аймгийн төсвийн татварын бус орлого аймгийн нийт орлогын дүнд нөлөөлж байна.....19

Б.2. Хүү, торгуулиас бүрдсэн орлогыг хууль, журмын дагуу хуваарилаагүй байна.....19

Б.2.1. Төсвийг хуваарилах эрх бүхий байгууллага бүрэн эрхийн хүрээнд зардлыг төсөвлөж ажиллажээ.....19-20

Б.2.2. Хуваарилалтыг хийхдээ ГХУС тухай хуульд заасан аргачлал, тооцоололд нийцүүлэн батлаагүй байна.....20

Б.2.3. Хүү, торгуулийн орлогоос зарцуулах ГХУСАЗСЗ-ийн зардлыг илүү, дутуу тооцож хуваарилсан байна.....20

Б.2.4. Орлогын төлөвлөгөө биелүүлсэн байдал, төвлөрүүлсэн орлогын хэмжээгээр албан хаагчдын ажил дүгнэх үзүүлэлтийг тусгайлан харгалзан үзэж дүгнэдэггүй байна.....21

В. ХҮҮ, ТОРГУУЛИЙН ОРЛОГЫН ЗАРЦУУЛАЛТ ҮР ДҮН БАГА БАЙНА.....21

В.1. Хүү, торгуулийн орлогыг хөрөнгө оруулалтын шинжтэй арга хэмжээнд зарцуулжээ.....21

В.1.1. Хүү, торгуулийн орлогын зарим зарцуулалтыг зориулалт бусаар зарцуулсан байна.....21-22

В.1.2. Зарим сум нь ГХУСАЗСЗ-ийн зардлыг зарцуулахдаа эдийн засгийн ангилал хооронд шилжүүлж, зарцуулжээ.....22

В.1.3. Хүү, торгуулийн орлогоор санхүүжүүлсэн арга хэмжээ нь олон нийтийн сургалт, арга хэмжээнд 2023 онд 95.2, 2024 онд 115.7 сая төгрөгийг тус тус зарцуулжээ.....22-23

В.1.4. Нийгэм, эдийн засагт нөлөө үзүүлэхүйц арга хэмжээнүүд хийгдсэн гэж дүгнэгдэж байна.....23

В.2. Хүү, торгуулийн орлогын зарцуулалтыг шилэн дансны тухай хуулийн хүрээнд мэдээлж байгаа ч ГХУСАЗСЗ нь олон нийтэд хийгдсэн ажлын тайлангаа тайлагнах ажил нь дутмаг байна.....23

В.2.1. Хүү, торгуулийн орлогын зарцуулалтыг шилэн дансанд мэдээлж ажиллажээ.....23-24

В.2.2. Эрх бүхий байгууллага нь хүү, торгуулийн орлогын зарцуулалтын тайлан, мэдээллийг шилэн дансны сайтад болон өөрийн байгууллагын самбараар мэдээлж ажиллажээ.....24

В.2.3. Иргэд, төрийн бус байгууллага, хяналтын зөвлөл зэрэг оролцогч талууд хүү, торгуулийн орлогын зарцуулалттай холбоотой асуудлыг зарим сумдын ГХУСАЗСЗ нь ил тод байдалд үнэлгээ өгч, санал хүргүүлэх, тайлагнах ажил дутмаг хийгдсэн байна.....24-25

Г.1. ХҮҮ ТОРГУУЛИЙН ОРЛОГЫН НЭГДСЭН БҮРТГЭЛ МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМ БАЙХГҮЙ, НОГДУУЛСАН ТОРГУУЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ ХИЙХ НӨХЦӨЛ БҮРДЭЭГҮЙ БАЙНА.....25

Г.1.1. Хүү, торгуулийн орлого бүртгэлийн нэгдсэн бүртгэл мэдээллийн системийг бүрэн нэвтрүүлээгүй, мэдээллийн сан бий болоогүй байна.....25

Г.1.2 Шийтгэврийн мэдээлэл нь нэгдсэн бүртгэлгүйгээс зарим төрлийн торгуулийг цахимаар төлөх нөхцөл хангагдаагүй байна.....26

Г.1.3. Нэгдсэн системээр хяналтыг хэрэгжүүлснээр орлого хянах, хугацаанд нь бүрэн төвлөрүүлэх, дараагийн шатны арга хэмжээг цаг алдалгүй авах зэрэг боломжууд бүрдэхээр байна.....26-28

Г.2. ХҮҮ, ТОРГУУЛИЙН ОРЛОГЫН НОГДУУЛАЛТАД, ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАН ХЯНАЛТ ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙГАА Ч БҮРДҮҮЛЭЛТЭД ТАВИХ ХЯНАЛТ СУЛ БАЙНА.....28

Г.2.1. Хугацаа хэтэрсэн торгуулиас ШШГГ албадан гүйцэтгүүлснээс өөр зохион байгуулалтын арга хэмжээ аваагүй байна.....28-29

Г.2.2. Торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад тусгайлан хяналт хэрэгжүүлээгүй, хууль журмын дагуу явцын хяналтууд хийгдэж байна.....29

Г.2.3. Торгуулийн орлого төвлөрүүлдэг байгууллагууд нь дотоод хяналт хэрэгжүүлээгүй байна.....29-30

Г.2.4. Аудитын хамрах хугацаанд иргэд, төрийн бус байгууллага, хяналтын зөвлөл зэрэг хөндлөнгийн байгууллагуудаас хяналт хэрэгжүүлээгүй байна.....30

ДҮГНЭЛТ.....30-31

ЗӨВЛӨМЖ.....31

САНАЛ.....31

ХАВСРАЛТ.....32-40

Товчилсон үгийн тайлбар

ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ХХААХҮ	Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэр
НББ	Нягтлан бодох бүртгэл
ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
ЖДҮДС	Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сан
ХХС	Хоршоо хөгжүүлэх сан
НТАГ	Нийслэлийн Төрийн аудитын газар
ГХУСАЗСЗ	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл
СТСХ	Санхүү төрийн сангийн хэлтэс
ТТХ	Төсвийн тухай хууль
ЗТХ	Зөрчлийн тухай хууль
ГХЗУСТХ	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль
ЗШШТХ	Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль
НДЕХ	Нийгмийн даатгалын ерөнхий хууль
ТЕХ	Татварын тухай хууль
ЗХАБТХ	Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль
БОХТХ	Байгаль орчныг хамгаалах тухай
НДТХ	Нийгмийн даатгалын тухай хууль
ХХҮГ	Хөдөлмөр халамж үйлчилгээний газар
СУАЖЗГ	Соёл урлаг, аялал, жуулчлал, залуучуудын газар
ЭБАТ	Эрх бүхий албан тушаалтан

Хүснэгтийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Аймгийн 2023, 2024 онуудын торгуулийн үлдээгдэлтэй иргэн, байгууллагын нэрсийн жагсаалт	11
Хүснэгт 2	Торгуулийн орлогын 2023, 2024 онуудын гүйцэтгэл	11
Хүснэгт 3	Аймаг, сумдын 2023, 2024 онуудад торгуулийн орлогын гүйцэтгэлээс ГХУСАСЗ-ийн зардлын хуваарилалтын жагсаалт	14
Хүснэгт 4	Аймаг, сумдын 2023, 2024 онуудад ГХУСАСЗ-ын зардлын гүйцэтгэл	15

Графикийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
График 1	Хүү, торгуулийн орлогын баталсан дүн, гүйцэтгэл	13
График 2		

Зургийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Зураг 1		
Зураг 2		
Зураг 3		
Зураг 4		

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл

Төрийн аудитын тухай хуулийн 6.3.1-д заасан төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд, Улсын Их Хурлын төсвийн байнгын хорооны 2024 оны 05 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2024 оны “Төрийн аудитын байгууллагын 2025 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө батлах тухай” А/108 дугаар тушаалыг үндэслэн Булган аймаг дахь Төрийн аудитын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу гүйцэтгэлээ.

Аудитын зорилт

“Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт” сэдвээр гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт, зөвлөмж боловсруулан дүнг, Монгол Улсын Их Хурал болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэгдэнэ. Аудитын зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд гүйцэтгэнэ. Үүнд:

- Хүү, торгуулийн орлогын төлөвлөлт нь хэрэгцээ шаардлагад нийцсэн эсэх.
- Хүү, торгуулийн орлого бүрдүүлэлтийг хууль, журамд нийцүүлэн төвлөрүүлсэн эсэх.
- Хүү, торгуулийн орлогын зарцуулалт үр дүнтэй эсэх.
- Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад тавих хяналт үр дүнтэй хэрэгжсэн эсэх.

Аудитын хамарсан хүрээ

Аудитад аймгийн хүү, торгуулийн орлого төлөвлөх, бүрдүүлэх, зарцуулах, хяналт хэрэгжүүлдэг төрийн байгууллагуудын холбогдох чиг үүргийн хэрэгжилт, 2023, 2024 онд хүү, торгуулийн орлогыг бүрдүүлсэн байдал, зарцуулалт, хяналт хэрэгжүүлэхтэй холбоотой тайлан мэдээ, дансны хуулга, бусад нотлох баримт материалыг хамруулсан болно.

Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитыг АДБОУБ (INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС 100, 300, 3000, Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817-6:2020, Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим, MNS 6817-7:2020, Гүйцэтгэлийн аудитын зарчим, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан “Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал” арга зүйг ашиглан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмжийг боловсрууллаа.

Аудитын бүрэлдэхүүн, хугацаа

Аудитыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Д.Батцогт хянан удирдаж, гүйцэтгэлийн аудитын үе шатны чанарын хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол хэрэгжүүлж, ахлах аудитор П.Мөнхтуяа, П.Содном нар аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу аудитыг гүйцэтгэсэн.

Үндсэн мэдээлэл

Аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэлийн аудитын үе шатны ажлыг 2025 оны 05 дугаар сарын 27-ны өдрөөс 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдөр хүртэл гүйцэтгэж, тайлагналын ажлыг 2024 оны 07 дугаар сарын 01-ний өдөр дуусгавар болгон аудитыг үе шатны хяналтаар хянуулж, аудитын тайлан, нотлох баримтыг бэлтгэж ажиллалаа.

Аймгийн хэмжээнд 16 сум, 1 тосгоны хүрээнд хүү, торгуулийн орлогын төлөвлөгөөг өмнөх оны гүйцэтгэлээр төлөвлөж ажилласан байна.

Үүнд: 2023 онд хүүгийн орлогын гүйцэтгэл 172.5 сая төгрөгийн гүйцэтгэлтэй, 2024 онд хүү орлого байхгүй, 2023 онд торгуулийн орлого 1,559.2, 2024 онд торгуулийн орлогыг 1,937.1 сая төгрөгөөр тус тус орлого төвлөрүүлсэн нь өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулбал 377.9 сая төгрөгөөр буюу 20 хувиар илүү орлого төвлөрүүлжээ.

2023-2024 онуудад 20 гаруй төр, төсвийн байгууллагууд торгуулийн орлого төвлөрүүлж ажилласан байна.

Тухайлбал: Улсын бүртгэлийн хэлтэс 16,8, ХХҮГ 8.0, ОБГ 5.8, МЭГ 2.4, ХХААГ 1.0, Татварын хэлтэс 144.5, СХДАГ 117.9, Цагдаагийн газар бэлэн бус орлого 1,787.7, торгууль, шийтгэврийн хуудсаар 599.5 сая төгрөгийг тус тус төвлөрүүлжээ.

**Хүндрэл
бэрхшээл**

А. ХҮҮ, ТОРГУУЛИЙН ОРЛОГЫГ БОДИТОЙ ТӨЛӨВЛӨХ, УРЬДЧИЛАН ТООЦОХ БОЛОМЖГҮЙ БАЙНА.

А.1.1. Хүүгийн орлогод зээлийн хүүд төлөх өр төлбөрийг төлөвлөсөн байна.

Аймгийн ИТХ-ын 2022 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн XII/21 тогтоолоор баталсан Булган аймгийн 2023 оны төсөвт хүүгийн орлогыг 1,356.6 сая төгрөгөөр баталж, төсвийн тодотголоор 1032.4 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 2389.0 сая төгрөг, 2024 онд 595.7 сая төгрөгөөр хүүгийн орлогыг төлөвлөн баталжээ.

Дээрх баталсан хүүгийн орлого нь орон нутгийн хотуудын нийтийн аж ахуйн хөгжлийн 2003 оны МОН-1907, 2011 оны МОН-2301, 2019 оны МОН-3713 гэсэн төслийн дамжуулан зээлдүүлэх гэрээний дагуу “Булган Мээж” ОНӨХХК, Тэшиг сумын ЗДТГ-аас аймгийн төсөвт тус зээлийн эргэн төлөлт хийх дүнгээс зээлийн хүүгийн төлөлтийг төлөвлөн баталсан байна.

Сангийн яам, аймгийн засаг даргын хооронд байгуулсан дамжуулан зээлдүүлэх гэрээнд ЗДТГ нь өрийн үлдэгдэлд жилийн 4.5 хувийн хүүг Сангийн яаманд жилд 2 удаагийн төлөлт хийж байхаар тусгасантай холбогдуулан Сангийн яам тооцооллыг хийж төсөвт тусгасан байна.

Хүснэгт № 1 Зээлийн эргэн төлөлт

ДЗ-ын дугаар	Валют	Зээлийн үлдэгдэл /2022.12.31	Төлсөн дүн	
			2023	2024
OL-1907MON-07	MNT	1,269.0	1,135.20	676
OL-2301MON-05	MNT	2,331.0	50.80	1507.8
OL-3713MON-1	USD	3,161,998.26		22850.7
	MNT	10,891.8		78.1

Дамжуулан зээлдэх гэрээний эргэн төлөлтийг “Булган Мээж” ОНӨХХК, Тэшиг сумын ЗДТГ-ууд аймгийн төсөвт төвлөрүүлэх гэрээ байгуулсан ч тус төлөлтүүд хийгдээгүй.

Аймгийн Засаг дарга Сангийн яамтай байгуулсан гэрээний дагуу аймгийн төсөвт баталж, эргэн төлөлтийг хийсэн байна.

Аймгийн хэмжээнд 16 сум 1 тосгоны ХХС, ЖДҮДС-гаар олгосон зээлийн хүүг ХХАА-н хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны А/361 дүгээр тушаалын хавсралтаар баталсан ХХС-гаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журмын 2.1.3, 2.1.4, 2.5.1-д заасан заалтуудыг үндэслэж тухайн зээлийн хүүгийн хувь хэмжээг тооцон, ХХС-гаас 2023 онд 1,494.0 сая төгрөгийн зээл олгосноос 141.8, 2024 онд 710.5 сая төгрөгийн зээл олгож 70.7 сая төгрөгийн хүү тус тус тооцон, зээлийн хүүгийн орлого 2023 онд 52.1, 2024 онд 39.7 сая төгрөгийг тухайн сумын хоршоо хөгжүүлэх сангийн дансанд төвлөрүүлжээ.

A.1.2. Торгуулийн орлогыг төсвийн бүрэлдэхүүн, хуульд заасан үндэслэл, шаардлагын дагуу төлөвлөж байна.

Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5-т “хяналт шалгалтын байгууллага улсын болон орон нутгийн төсөвт орлого оруулах үүрэг хүлээхгүй” гэж заасны дагуу зөрчил шалган шийдвэрлэх ЭБАТ-тай байгууллага нь торгуулийн орлогыг тодорхой түвшинд төлөвлөдөггүй, Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3¹ т заасан төсвийн орлогын нэг хэсэг болох торгуулийн орлогыг Сангийн яамнаас хянаж ирүүлсэн төлөвлөгөөний дагуу аймаг сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаар хэлэлцүүлэн, тогтоолуудаар баталж, тодотгон 2023 онд 1,086.4, 2024 онд 1,538.4 сая төгрөгөөр төлөвлөн баталжээ.

Торгуулийн орлого нь төсвийн эх үүсвэрийг жил бүр 1.5-1.9 тэрбум төгрөгөөр бүрдүүлж байгаа нь тухайн орлогыг төлөвлөхгүй бол төсвийн бусад эх үүсвэрийг энэ хэмжээгээр нэмэгдүүлэх, эсвэл зардлыг бууруулан төлөвлөх шаардлага үүсэж байна.

Торгуулийн орлогыг төлөвлөснөөр Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1², “Авто замын тухай” хуулийн 25 дугаар зүйлийн 25.2.4³-д заасны дагуу орлогын тодорхой хувийг зориулалтын дагуу төлөвлөж, хэрэгжүүлэх нөхцөл бүрдсэн нь бодит хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

Аймгийн ГХУСАЗСЗ-ийн зардлыг 2023 онд 336.6, 2024 онд 530.1 сая төгрөгөөр тус тус баталсан, аймгийн авто замын санд хуульд заасны дагуу торгуулийн орлогоос хуваарилан тооцож, төлөвлөөгүй байна.

Торгуулийн орлогыг хэт өндөр, бодитой бус төлөвлөх нь хууль сахиулагчдыг “орлого төвлөрүүлэгч” болгон хувиргаж, зөрчил бууруулах үндсэн зорилгыг алдагдуулах, зарим иргэн, хуулийн этгээдэд санхүүгийн дарамт үүсгэх, ЭБАТ-уудад ашиг сонирхлын зөрчил үүсгэх зэрэг олон сөрөг үр дагаврыг бий болгох талтай ч нөгөө талаас торгууль нь хууль, журам сахиулах гол хөшүүрэг болж байна.

A.2. ХҮҮ, ТОРГУУЛИЙН ОРЛОГЫГ ГҮЙЦЭТГЭЛД ҮНДЭСЛЭН ТӨЛӨВЛӨСӨН БАЙНА.

A.2.1. Торгуулийн орлого нь сүүлийн 3 жилд 125.9-143.5 хувиар давж биелсэн байна.

Аймгийн торгуулийн орлогыг 2023 онд 1,086.5 сая төгрөгөөр төлөвлөн гүйцэтгэл 1,559.2 сая төгрөг буюу 143.5 хувиар, 2024 онд 1,538.5 сая төгрөгөөр төлөвлөн гүйцэтгэлээр 1,937.1 сая төгрөг буюу 125.9 хувиар давж биелсэн үзүүлэлттэй байна

Хүснэгт № 2 Торгуулийн орлогын 2023, 2024 оны төлөвлөгөө, гүйцэтгэл

/сая төгрөг/

	2023	2024	
--	------	------	--

¹ Татварын бус орлого нь төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрийн болон орон нутгийн өмчид ногдох хувьцааны ногдол ашиг, төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийг ашигласны төлбөр, төрийн болон орон нутгийн өмчийг түрээсэлсний орлого, торгуулийн орлого, төсвийн байгууллагын туслах үйл ажиллагааны орлого, Засгийн газрын зээллэг, тусламж болон хууль тогтоомжийн дагуу төсөвт төвлөрүүлэх бусад орлогоос бүрдэнэ.

² торгуулийн орлогын 40-өөс доошгүй хувийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр дараа жилийн төсөвт тусгаж, санхүүжүүлнэ

³ замын сангийн эх үүсвэрт нийслэл, орон нутгийн авто зам дээр хөдөлгөөний аюулгүй байдлын зөрчил гаргасан, авто замын талаарх хууль тогтоомжийг зөрчсөн этгээдэд ногдуулсан торгууль

“Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт”

Сумын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	биелэлт /+/-	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	биелэлт /+/-
Аймаг төсөв	151.20	258.32	107.12	69.74	225.54	155.80
Баян-Агт	12.00	14.60	2.60	12.00	6.44	-5.56
Бугат	22.00	24.81	2.81	36.00	61.90	25.90
Бүрэгхангай	45.00	39.89	-5.11	71.00	142.23	71.23
Гурванбулаг	10.00	10.27	0.27	10.00	8.26	-1.74
Дашинчилэн	20.00	38.79	18.79	30.00	42.81	12.81
Могод	10.00	9.29	-0.71	10.00	6.48	-3.52
Орхон	41.00	36.40	-4.60	36.00	48.89	12.89
Сайхан	9.00	11.00	2.00	9.00	9.55	0.55
Сэлэнгэ	23.86	30.45	6.59	28.66	15.28	-13.38
Тэшиг	12.00	10.34	-1.66	12.00	9.29	-2.71
Хангал	40.40	46.54	6.14	55.40	58.15	2.75
Хишиг-Өндөр	12.00	14.36	2.36	21.54	31.21	9.67
Хутаг-Өндөр	80.00	145.25	65.25	130.00	153.28	23.28
Баяннуур	83.00	104.71	21.71	83.00	87.20	4.20
Рашаант	210.00	318.16	108.16	538.14	391.40	-146.75
Хялганат	25.00	41.67	16.67	53.00	97.60	44.60
Булган сум	280.00	404.39	124.39	333.00	541.61	208.61
Дүн	1,086.46	1,559.23	472.77	1,538.49	1,937.12	398.63

Торгуулийн орлогын төлөвлөлт, биелэлт сумдын хүн амын нягтрал, улсын чанартай авто замын сүлжээ дайран өнгөрөх бүс нутаг, сум бүрийн зөрчлийн тоо хэмжээ, хяналт шалгалт, хэрэгжилтийн ялгаатай байдал зэргээс шалтгаалан харилцан адилгүй байна.

Тухайлбал: Авто замын дагуух Орхон, Булган сум, Хангал, Рашаант сумууд төлөвлөснөөс давсан бол, алслагдсан Тэшиг, Дашинчилэн, Баян-Агт зэрэг сумдад орлого тасарсан байна.

Энэ нь торгуулийн орлогыг урьдчилан тооцож, төлөвлөх боломжгүй, тохиолдлын шинж чанартай байгаагаас шалтгаалсан байна.

A.2.2 Торгуулийн орлогыг төлөвлөхдөө орлого бүрдүүлдэг байгууллагуудын зөрчлийн тоо хэмжээ, хэрэгжилт зэрэг суурь судалгаа мэдээлэл, дүн шинжилгээг хийгээгүй байна.

Торгуулийн орлогыг төлөвлөхдөө орлого бүрдүүлдэг байгууллагуудын зөрчлийн тоо хэмжээ, хэрэгжилт зэрэг суурь судалгаа мэдээлэл, дүн шинжилгээг хийгээгүй, зөвхөн орлогын гүйцэтгэлд тулгуурлан төлөвлөсөн, ингэхдээ аймгийн хэмжээгээр өмнөх оноос 452.0 сая төгрөгөөр буюу 40 гаруй хувиар нэмж төлөвлөсөн байна. Энэ нь өмнөх оны торгуулийн орлогын төлөгдөөгүй дүнгээр тооцсон гэх боловч тооцоо судалгаа байхгүй байна.

**Хүснэгт № 3 Өмнөх жилүүдийн төлөвлөгөө гүйцэтгэлийн харуулбал
/сая төгрөг/**

№	Сумдын нэр	2022		2023		2024	
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Баян-Агт	3.00	12.73	12.00	14.62	12.00	6.44
2	Бугат	13.00	18.99	22.00	24.81	36.00	61.90

“Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт”

3	Бүрэгхангай	20.00	53.58	45.00	39.89	71.00	142.23
4	Гурванбулаг	10.00	7.18	10.00	10.27	10.00	8.26
5	Дашинчилэн	20.00	23.86	20.00	38.79	30.00	42.81
6	Могод	8.00	13.99	10.00	9.29	10.00	6.48
7	Орхон	27.00	46.37	41.00	36.40	36.00	48.89
8	Сайхан	7.50	11.37	9.00	11.00	9.00	9.55
9	Сэлэнгэ	21.00	9.73	23.86	30.45	28.66	15.28
10	Тэшиг	15.00	15.01	12.00	10.34	12.00	9.29
11	Хангал	20.00	23.93	40.40	46.54	55.40	58.15
12	Хишиг-Өндөр	16.00	15.40	12.00	14.36	21.54	31.21
13	Хутаг-Өндөр	109.56	72.22	80.00	145.25	130.00	153.28
14	Булган	280.00	296.86	280.00	404.39	333.00	541.61
15	Баяннуур	60.00	77.89	83.00	104.71	83.00	87.20
16	Рашаант	151.00	169.38	210.00	318.16	538.14	391.40
17	Хялганат	25.00	30.10	25.00	41.67	53.00	97.60
18	Аймаг	246.50	238.89	151.20	258.32	69.74	225.54
19	Нийт	1,052.56	1,137.46	1,086.46	1,559.25	1,538.49	1,937.12

Дээрх хүснэгтээс үзэхэд 10 сумын орлогыг 312.8 сая төгрөгөөр бууруулсан, 8 сумын орлогыг 292.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж баталсан байна.

Үүнээс төлөвлөлт өссөн, буурсан зарим сумдыг авч үзвэл, аймгийн торгуулийн орлогыг өмнөх 2 жилд 238.9-258.3 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байхад 2024 онд 69.7 сая төгрөг болгон бууруулж батлан гүйцэтгэлээр 225.5 сая төгрөгийн орлого төвлөрч 155.8 сая төгрөгөөр давж биелсэн, мөн Булган сумын торгуулийн орлого өмнөх жилд 296.9-404.0 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байхад 2024 онд 333.0 сая төгрөг болгон бууруулж, гүйцэтгэлээр 541.6 сая төгрөгийн орлого орж 208.6 сая төгрөгөөр давж биелсэн бол Рашаант сумын торгуулийн орлого 2022 онд 169.4, 2023 онд 318.1 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байхад 538.1 сая төгрөг болгон нэмэгдүүлж, гүйцэтгэлээр 391.4 сая төгрөг төвлөрч 146.7 сая төгрөгөөр тасарсан байна.

Сумдын торгуулийн орлогыг хэрхэн өсгөж, бууруулж төлөвлөсөн нь талаарх мэдээлэл судалгаа, тооцоо байхгүй байна.

А.2.3. Хүүгийн орлогыг зээлийн гэрээнд заасан хувь хэмжээгээр тооцон төлөвлөж байна.

Аймгийн 2023, 2024 оны хүүгийн орлогыг “Булган Мээж” ОНӨХХК, Тэшиг сумын ЗДТГ-д шилжүүлэн олгосон зээлийн гэрээний дагуу 2023 онд 1,356.6 сая төгрөг, 2024 онд 595.7 сая төгрөгийн зээлийн хүү төлөхтэй холбоотой төлөвлөсөн. “Булган Мээж”, ОНӨХХК, “Тэшиг-Ус ОНӨААТҮГ нь төлөлт хийх санхүүгийн нөөцгүйгээс хүүгийн эргэн төлөлтийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлсэн байна.

Хүүгийн орлогыг ханшийн хэлбэлзэл, эдийн засгийн нөхцөл байдлаас хамаарахгүйгээр зээлийн гэрээнд заасан хүүгийн хувь хэмжээг үндэслэн эргэн төлөлтийн орлоготой уялдуулан төлөвлөж байна.

Сумдын Хоршоо хөгжүүлэх сангаас олгогдож буй хөнгөлөлтэй зээлийн хүүгийн орлогыг төлөвлөхдөө тухайн сангийн өмнөх жилд олгосон зээлийн хүүгийн орлого, тайлант онд олгогдох зээлийн хүүгийн орлого зэргийг үндэслэн тооцож байна.

А.2.4. Авто замын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2.4 дэх заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Торгуулийн орлогоос дараах хуульд заасан арга хэмжээнд зарцуулахаар тооцоолсон байна. Үүнд:

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1-д заасан зөрчлүүдэд оногдуулсан торгох шийтгэлээс төсөвт төвлөрсөн орлогын 40-өөс доошгүй хувийг дараагийн төсвийн жилд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зарцуулахаар заасны дагуу торгуулийн орлогыг жил бүр төлөвлөж байна.

Авто замын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2.4-т “нийслэл, орон нутгийн авто зам дээр хөдөлгөөний аюулгүй байдлын зөрчил гаргасан, авто замын талаарх хууль тогтоомжийг зөрчсөн этгээдэд ногдуулсан торгууль”-ийг авто замын сангийн эх үүсвэр болгож, зарцуулахаар заасан ч төсөвт тусгаагүй байна. Энэ нь улс, орон нутгийн чанартай авто зам дээр гаргасан зөрчилд ноогдуулж байгаа торгуулийн орлогыг эрх бүхий байгууллага, албан тушаалтнууд тус хуулийн дагуу авто замын санд төвлөрүүлэхгүй байгаагаас шалтгаалан төсөвт төлөвлөх боломжгүй гэдэг тайлбарыг өгч байна.

Харин сумдын “Хоршоо хөгжүүлэх сан”-гийн зээлийн хүүгийн орлогыг тухайн сумдын Хоршоо хөгжүүлэх сангаас дараа онд олгох зээлийн эх үүсвэрийн нэг хэсэг болгон төлөвлөж байна.

А.2.5. Хүү, торгуулийн орлогын гүйцэтгэлд дүн шинжилгээ хийж, нэг удаагийн тогтмол бус орлогыг тодорхойлж, орлогын нөхцөл байдлыг судлах шаардлагатай байна.

Аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс нь төсвийн орлогын төлөвлөлтийг хийхдээ өмнөх жилүүдийн төсвийн орлогын гүйцэтгэлийг харьцуулан, суурь мэдээлэл болгон ашигладаг байна.

Төсвийн төсөлд хүү, торгуулийн орлогыг тайлант оны хүлээгдэж буй гүйцэтгэл өмнөх жилийн гүйцэтгэл зэргийг үндэслэн төлөвлөж Сангийн яаманд хүргүүлсэн байна.

Хүү, торгуулийн орлогын гүйцэтгэлд торгуулийн орлого бүрдүүлдэг эрх бүхий байгууллагуудын тогтоосон болон хэрэгжсэн орлогын дүнд нарийвчлан шинжилгээ хийгээгүй байна.

Аймгийн 2023 оны төсвийн орлогод хүүгийн орлогоос 1356.6 сая төгрөгийг төлөвлөсөн бөгөөд гүйцэтгэл 0.0 хувьтай байгаа хэдий ч 2024 онд 595.7 сая төгрөгөөр дахин төлөвлөгөөнд тусгаж байгаа нь “Булган Мээж” ОНӨХХК, Тэшиг сумын ЗДТГ-д шилжүүлэн олгосон зээлийн гэрээний эргэн төлөлтийн хүүгийн зардлын эх үүсвэрийг төлөвлөх шаардлагатай болсон нь нөлөөлжээ.

Хүү торгуулийн орлого өмнөх жилүүдэд нийт дүнгээрээ 2023 онд 1,559.2 сая төгрөг буюу 143.5 хувиар, 2024 онд 1,937.1 сая төгрөг буюу 125.9 хувиар давж биелсэн байна.

Аймгийн торгуулийн орлогыг өмнөх 2024 онд 225.5 сая төгрөгийн орлого төвлөрч 155.8 сая төгрөгөөр давж биелсэн, мөн Булган сумын торгуулийн орлого 541.6 сая төгрөгийн орлого орж 208.6 сая төгрөгөөр давж биелсэн бол Рашаант сумын торгуулийн орлогыг 538.1 сая төгрөг болгон 328.1 сая төгрөгөөр нэмэгдүүлж, гүйцэтгэлээр 391.4 сая төгрөг төвлөрч 146.7 сая төгрөгөөр тасарсан байна.

Судалгаагаар 2023, 2024 онуудад нийт 4512 иргэн, хуулийн этгээдэд 3,753.1 сая төгрөгийн торгууль ногдуулснаас орон нутгийн төсөвт 2,935.2 сая төгрөгийн торгуулийн орлого төвлөрсөн байна.

Энэ нь зөвхөн орон нутгийн орлогын дансанд орсон мөнгөн дүнг үндэслэн төлөвлөлт хийж байгаатай холбоотой байна.

Иймд хүү, торгуулийн орлогын гүйцэтгэлийг эрх бүхий төрийн байгууллагуудаас тогтоосон торгууль болон хэрэгжсэн орлогын гүйцэтгэлд үндэслэн дүн шинжилгээ хийж, давсан дутсан шалтгаан нөхцөлийг тодорхойлж төлөвлөх шаардлагатай байна.

А.2.6. Эх үүсвэрийг зөвхөн өмнөх оны орлогын гүйцэтгэлд үндэслэн төлөвлөсөн байна.

Аймгийн хэмжээнд 2023 онд 1559.2 сая төгрөг, 2024 онд 1937.1 сая төгрөгийн татварын торгууль төвлөрсөн. Гэвч татварын торгуулийн орлого нь хяналт шалгалтын үр дүнд бий болдог бөгөөд хяналт шалгалт хийх эсэх, шалгалтаар зөрчил илрэх эсэх, хэдий хэмжээний торгуулийн орлого төвлөрөх нь тодорхойгүй тул аймаг болон 16 сум, 1 тосгон нь зөвхөн өмнөх жилүүдийн гүйцэтгэлд үндэслэн тооцож төлөвлөсөн байна.

А.3. ХҮҮ, ТОРГУУЛИЙН ОРЛОГОТӨЙ ХОЛБООТӨЙ ЗАРИМ ХУУЛИЙН ЗААЛТУУД ХООРОНДОО НИЙЦЭХГҮЙ БАЙНА.

А.3.1. Хүү, торгуулийн орлого бүрдүүлэлтийн хууль, эрх зүйн орчин нь бодит хэрэгцээ шаардлагыг хангахаар хуульчлагдсан ч зарим тохиолдолд хоорондоо уялдахгүй байна.

Орон нутгийн төсвийн орлогод төвлөрч байгаа торгуулийн орлогоос 2023 онд 84, 2024 онд 78 хувийг цагдаагийн байгууллагын торгууль, шийтгэврийн хуудсаар болон бэлэн бусаар торгосон орлогууд эзэлж байгаагаас авто замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчсөн торгуулийн орлого зонхилж байгаа ч аймагт төсвийн орлогыг төвлөрүүлэхдээ авто замын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2.4 дэх хэсэг⁴ гэж заасны дагуу тус зөрчлөөр илэрсэн торгуулийн орлогыг автозамын сангийн дансанд төвлөрүүлэхгүйгээр, орон нутгийн хүү торгуулийн орлогын дансанд төвлөрүүлэхээр системчлэгдсэн байна.

⁴ “нийслэл, орон нутгийн авто зам дээр хөдөлгөөний аюулгүй байдлын зөрчил гаргасан, авто замын талаарх хууль тогтоомжийг зөрчсөн этгээдэд ногдуулсан торгууль”

Мөн хуулийн 24 дүгээр зүйлийн 24.9.-д⁵ гэж заасны дагуу зам засварын ажилд зарцуулах санхүүжилтийг аймгийн татварын орлогоос хуваарилан төлөвлөж байна.

ГХУС тухай хуулийн 46 дүгээр зүйлийн 46.5.8-д⁶, Нийгмийн даатгалын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.3-т⁷ гэсэн заалтууд хоорондоо зөрчилдөж байна.

А.3.2. Хүү бодох аргачлал, хугацаа, хүүгийн хувь хэмжээ тодорхой хуульчлагдсан байна.

Аймгийн хэмжээнд 16 сум 1 тосгоны ХХС, ЖДҮДС-гаар олгосон зээлийн хүүг ХХААХҮ-ийн Сайдын 2021 оны А/361 дүгээр тушаалын хавсралтаар баталсан ХХС-гаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журмын 2.5.2.5-т⁸, 2.5.1-д⁹, 2.5.2.¹⁰, 2.5.3-т¹¹, 2.5.4-т¹², Засгийн газрын 2020 оны 113 дугаар тогтоолын хавсралтаар баталсан ЖДҮДС-гаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт тавих журмын 4.2.4-т¹³ гэсэн заалтуудыг үндэслэж тухайн зээлийн хүүгийн хувь хэмжээг тооцон ажиллажээ.

Тухайлбал: Сумд нь ХХС-гаас 2023 онд 1,494.0 сая төгрөгийн зээл олгосноос 141.8, 2024 онд 710.5 сая төгрөгийн зээл олгож 70.7 сая төгрөгийн хүү тус тус тооцсон байна.

ЖДҮДС-гаас 2023 онд 151.2 сая төгрөгийн зээл олгосноос 2.5, 2024 онд 128.5 сая төгрөгийн зээл олгож 24.7 сая төгрөгийн хүүг тус тус тооцжээ.

НДС-гийн хүү 2023 онд 43.1, 2024 онд 79.0 сая төгрөгийг тухайн нэгдсэн сангийн дансанд төвлөрүүлж 16 сум 1 тосгоны тэтгэвэр, тэтгэмж, ажилгүйдэл, ҮОМШӨ, ЭМД-ын сангийн сумын дансанд нь хуваарилан ажилласан байна.

Сангийн яамнаас ирүүлсэн дамжуулангийн зээлийн хүү тооцсон дүнг аймаг 2023 онд 2,389.0, 2024 онд 595.7 сая төгрөгөөр хүүгийн орлогын төлөвлөгөөнд тусгаж ажилласан боловч гүйцэтгэлээр хүүгийн орлого төвлөрөөгүй нь “Булган мээж” ОНӨХХК, “Тэшиг ус” ОНӨААТҮГ-ууд нь 2023, 2024 онуудад ашиггүй ажилласан шалтгаанаас үүссэн гэж үзэж байна.

Дээрх ХХС, ЖДҮДС, НДС-гаас тооцсон хүүгийн төлөлт аймгийн орлогын дансанд төвлөрдөггүй, тухайн байгууллагын дансанд төвлөрдөг тул нэгтгэл судалгаанд оруулж нэгтгээгүй болно.

А.3.3. Хуулийн зарим нэг заалтууд нь хоорондоо уялдаагүй байна.

Сангийн сайдын 2016 оны 107 дугаар тушаалаар баталсан Санхүүгийн хяналт шалгалтын стандартын 3 дугаар зүйлийн 3.4.15-д¹⁴ гэж заасан боловч Зөрчлийн тухай хууль болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиудад уг заалтыг хэрхэн хэрэгжүүлэх талаар тусгаагүй байна.

А.3.4. Торгуулийн хэмжээ нь үйлдсэн зөрчилтэй нь нийцэж байна.

Аймгийн хэмжээнд 2023 онд 38108 тооны 2,008.2 сая, 2024 онд 41047 тооны 1,750.9 сая төгрөгийн буюу нийт 79155 тооны 3,759.1 сая төгрөгийн зөрчил илрүүлж

⁵ “Тухайн жилд улсын авто замын сангийн хөрөнгөөр гүйцэтгэх ажил, зарцуулах хөрөнгийг авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, нийслэл, орон нутгийн чанартай авто замын сангийн хөрөнгөөр гүйцэтгэх ажил, зарцуулах хөрөнгийг аймаг, нийслэлийн Засаг дарга тус тус баталж, хэрэгжүүлнэ

⁶ олон нийтийн цагдаагийн урамшуулал, эрүүл мэндийн даатгалын зардлыг санхүүжүүлэх

⁷ “ажил олгогчоос даатгуулагчид мөнгөн хэлбэрээр олгосон хоол, унаа, түлээ, нүүрсний үнийн хөнгөлөлт, орон сууцны ашиглалтын төлбөр, тэдгээртэй адилтгах бусад орлого, сар, улирал, жилийн ажлын үр дүнг харгалзан олгосон шагнал, урамшуулал

⁸ Сангаас хоршоонд олгох хөнгөлөлттэй зээл нь дараах нөхцөлтэй байна.

⁹ хөнгөлөлттэй зээлийн хүүгийн хэмжээ жилийн 3 хувь,

¹⁰ “зээлийн хугацаа нь 60 хүртэл сар байна.”

¹¹ “зээлийн эргэн төлөлтийн эхний 12 хүртэлх сарын хугацаанд үндсэн төлбөрөөс чөлөөлж болно.”

¹² “сангийн зээлийн эргэн төлөлтийн төлбөр нь сар эсхүл улирал бүр тэнцүү байна.”

¹³ “энэ журмын дагуу олгох хөнгөлөлттэй зээлийн хүүгийн хэмжээ тухайн банкны жижиг, дунд үйлдвэрийн зориулалттай зээлийн хүүгийн доод түвшингээс бага байх;”

¹⁴ “Шалгалтын явцад төрийн хууль тогтоомжийг зөрчсөн, улсад эд хөрөнгийн хохирол учруулсан нь тогтоогдвол гэм буруутай албан тушаалтанд захиргааны шийтгэл ногдуулж, шийтгэвэр бичиж торгууль хүлээлгэнэ”

ГХУС тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Татварын тухай хууль, НББ-ийн тухай хууль, Авто тээврийн тухай хууль болон бусад холбогдох хуулийн заалтуудыг үндэслэн торгууль тогтоосон нь хууль журамд нийцсэн үгүйг аймгийн Прокурорын газарт жил бүр торгууль тогтоох эрх бүхий байгууллагын албан тушаалтан ногдуулсан торгуулийн орлогын шийтгэврийн хуудас, холбогдох анхан шатны баримт материалыг хянуулсны үндсэн дээр тухайн торгуулийг тогтоож ажилладаг байна.

А.3.5. Хууль хэрэглээ нь бүх нийтэд хуульд заасан хувь хэмжээгээр торгууль тогтоож байгаа ч торгуулийг 50 хувиар хөнгөлөх заалт хэрэгжсэнээр иргэд, хуулийн этгээдэд эергээр нөлөөлж байна.

Зөрчил гаргасан иргэд, аж ахуйн нэгжүүдэд улсын байцаагчийн эрхтэй албан тушаалтан зөрчлийг илрүүлж тухайн зөрчилд холбогдох хуульд заасан хэмжээгээр торгууль тогтоосон байна.

Тогтоосон торгууль шийтгэврээс буруу үндэслэлээр тогтоосон нь илэрч гомдол гаргасан тоон мэдээлэл 2023, 2024 онуудад байхгүй байгаа нь олон нийтэд хуулийн хэрэглээг адил тэгш үйлчилсний илрэл юм.

Мөн Зөрчлийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлтөөр торгуулиа хугацаандаа төлсөн иргэн, хуулийн этгээдийн торгуулийг 50 хувиар хөнгөлөх хуулийн заалт хэрэгжсэн нь иргэд, хуулийн этгээд хугацаандаа торгуулиа төлөхөд эергээр нөлөөлөх үндэслэл болж байна.

А.3.6. Орлого бүрдүүлэлтийн эрх зүй болон ашиглаж буй системд шинэчлэл, сайжруулалт хийх хэрэгцээ шаардлага үүсэж байна.

Зөрчлийн тухай хуулиар торгууль тогтоосон зарим нэг зөрчил нь иргэн, хуулийн этгээдэд дарамт үүсгэх магадлалтай заалтууд байна.

Энэ нь Зөрчлийн тухай хуулийн 11.18 дугаар зүйлийн 1.6¹⁵-д заасан зөрчлийг гаргасан хуулийн этгээдийг 4000 нэгжээр торгох, мөн Улсын ерөнхий прокурор, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2024 оны А/42, А/71 дугаар хамтарсан тушаалаар баталсан Эрх бүхий албан тушаалтнаас оногдуулсан торгох шийтгэлийг нэмэгдүүлж тооцох хугацаа, аргачлалын 2.2-т¹⁶ гэсэн заалтууд санхүүгийн хувьд зарим тохиолдолд нөлөөлөх эрсдэлтэй байна.

Аймаг, сумдын торгуулийн орлого бүрдүүлж байгаа байгууллагуудаас цагдаагийн байгууллагын торгуулийн орлогыг тулгахад шийтгэврийн хуудсаар тогтоосон торгуулийн орлого нь орон нутгийн нэгдсэн дансанд төвлөрүүлж байгаа ч бэлэн бусаар торгосон тохиолдолд smartcar, geregge, e-mongolia, toki, torquuli.mn банк зэргээр төлөгдөж байна.

Торгууль төлж байгаа иргэн аж ахуйн нэгжүүд нь торгууль төлөхдөө нэр, регистр болон холбогдох хувийн мэдээллээ дутуу оруулж төвлөрүүлснээс мөн цагдаагийн байгууллага нь зөрчил гаргасан иргэн, аж ахуйн нэгжүүдийн зөрчлийг “од” программаас ногдуулалт, төвлөрүүлэлтийг зөрчлийн ангиллаар нь шүүж гаргадаг ч тус программын хувьд тухайн оны торгууль тогтоосон орлого болон

¹⁵ 1.6.аж ахуйн нэгж, байгууллага санхүүгийн тайлангаа хуулиар тогтоосон хугацаанд харилцагч санхүүгийн байгууллагад цахим хэлбэрээр хүргүүлэх үүргээ биелүүлээгүй;

¹⁶ “Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээд нь эрх бүхий албан тушаалтнаас оногдуулсан торгох шийтгэлийг Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 7.5 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан хугацаанд биелүүлээгүй тохиолдолд оногдуулсан торгох шийтгэлийн хэмжээг хугацаа хэтрүүлсэн сар бүр 10 хувиар нэмэгдүүлэн тооцно. Шийтгэлийн хувь хэмжээг нэмэгдүүлэн тооцох нийт хугацаа 5 сараас, нийт хувь хэмжээ нь торгох шийтгэлийн 50 хувиас хэтрэхгүй байна

төвлөрүүлсэн нь мэдэгдэхээс, өмнөх оноос хэдэн төгрөгийн орлого, хэнээс орсныг бүрэн тулгах боломжгүй байгаа нь учир дутагдалтай байна.

А.3.7. Хүү, торгуулийн орлого нь иргэний өмчийн халдашгүй байдалтай зөрчилдөөгүй байна.

Аудитын явцад аймгийн Татварын газар, СТХС-ээс аудитын асуудалтай холбоотой асуумж хийхэд торгууль нь хуулиар зохицуулагдсан заалт, журмын хүрээнд зөрчигдсэн заалт байхгүй гэсэн асуумжийг өгч ажиллалаа.

Зөрчил үйлдсэн иргэн, хуулийн этгээд нь Иргэний тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-д¹⁷, 70 дугаар зүйлийн 70.1-д¹⁸ гэсэн заалт нь хуулиар зохицуулагдсан бусад хууль, тогтоомжтой нийцсэн гэж үзэж байна.

Б. ХҮҮ, ТОРГУУЛИЙН ОРЛОГО БҮРДҮҮЛЭЛТИЙГ ХУУЛЬ, ЖУРАМД НИЙЦҮҮЛЭН АЖИЛЛАСАН Ч 2023-2024 ОНУУДЫН НОГДУУЛСАН ТОРГУУЛИЙН ОРЛОГООС 819.2 САЯ ТӨГРӨГИЙН ҮЛДЭГДЭЛТЭЙ БАЙНА.

Б.1. Торгуулийн орлогын гүйцэтгэл 2023 онд 458.9, 2024 онд 398.6 сая төгрөгөөр илүү орлого төвлөрсөн нь хугацаандаа торгуулиа төлөөгүйгээс торгууль нэмэгдэж төлөгдсөн, мөн өмнөх оны үлдэгдэл төвлөрсөнтэй холбон үзэж байна.

Б.1.1. Хууль, журмын дагуу тогтоож ногдуулсан торгуулийн орлогыг төсөвт 2023 онд 85.7, 2024 онд 69.4 хувийн биелэлтэй гарчээ.

Аймгийн хэмжээний торгуулийн орлогын нэгтгэл судалгаагаар 2023 онд 2,002.2 сая төгрөгийн торгууль тогтоосноос 1717.2, 2024 онд 1,750.9 сая төгрөгийн торгуулиас 1,218.1 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлснээс 2023 онд 2.3, 2024 онд 2.4 сая төгрөгийг илүү оруулж, 2023 онд 286.9, 2024 онд 532.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Торгуулийн үлдэгдэлтэй иргэн, байгууллагын нэрсийг хавсралт хүснэгт №1 харуулав.

Хавсралт хүснэгтээс үзэхэд торгуулийн орлогын үлдэгдлийг 2023 онд 72, 2024 онд 80 хувийг тус тус аймгийн Цагдаагийн газар эзэлж байна.

Б.1.2. Торгуулийг эрх бүхий байгууллага, албан тушаалтан бичиж хүргүүлсэн байна.

Аймгийн хэмжээнд торгууль тогтоох 26 байгууллагын улсын байцаагчийн эрхтэй 129 албан тушаалтан байгаагаас 2023, 2024 онуудад торгууль тогтоосон 22 байгууллагын 123 албан тушаалтан торгууль, шийтгэврийн хуудсаар 2023 онд 705.8, 2024 онд 733.4, бэлэн бусаар 2023 онд 1,296.4, 2024 онд 1,017.5 сая төгрөгийн торгууль тус тус тогтоожээ.

Үүнээс: Статистик хэлтэс, Стандарт хэмжил зүйн хэлтэс, ХХҮГ, СУАЖЗГ зэрэг нь торгууль бичигдээгүй нь хүний нөөцийн дутагдалтайгаас, мөн зөрчил илрээгүйгээс шалтгаалжээ.

¹⁷ Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.

¹⁸ Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино.

Б.1.3. Орлого бүрдүүлэлтийг аймгийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аймгийн төсвийн орлогын дансанд төвлөрсөн гүйцэтгэлийн дүнгээр тайлагнасан байна.

Аймгийн ТЕЗ-ийн 2023, 2024 онуудын санхүүгийн нэгтгэсэн тайланд аймгийн, 16 сум 1 тосгоны хүрээнд торгуулийн орлогын гүйцэтгэлийн нийт дүнгээр нэгтгэн тайлагнасан байна.

Торгуулийн орлогын 2023, 2024 онуудын гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №4 /сая.төг/

№	Сумдын нэр	Торгуулийн орлогын гүйцэтгэлийн дүн	
		2023 он	2024 он
1	Баян-Агт	0.6	6.4
2	Бугат	24.8	61.9
3	Бүрэгхангай	39.9	142.2
4	Гурванбулаг	10.3	8.2
5	Дашинчилэн	38.8	42.8
6	Могод	9.3	6.5
7	Орхон	36.4	48.9
8	Сайхан	11.0	9.5
9	Сэлэнгэ	30.4	15.3
10	Тэшиг	10.3	9.3
11	Хангал	46.5	58.1
12	Хишиг-Өндөр	14.3	31.2
13	Хутаг-Өндөр	145.2	153.3
14	Булган	404.4	541.6
15	Баяннуур	104.7	87.2
16	Рашаант	318.2	391.4
17	Хялганат	41.7	97.6
18	Аймаг	258.3	225.5
Нийт		1,545.3	1,937.1

Дээрх сумдын 2023, 2024 онуудын торгуулийн орлогын гүйцэтгэлийн дүнг төлөвлөгөөтэй харьцуулахад 2023 онд 458.9 сая төгрөг буюу 30 хувь, 2024 онд 398.6 сая төгрөг буюу 21 хувиар тус тус нэмэгдсэн нь өмнөх онуудын орлого төлөгдсөн, мөн цагдаагийн орлогын гүйцэтгэлийг бодитойгоор тодорхойлох боломжгүй, орлогын дансны хуулгаар л нэгтгэж дүнг гаргадаг, иргэн, аж ахуйн нэгж орлого төвлөрүүлэхдээ нэр, регистр, он, сар өдрөө бүрэн бичиж хийгддэггүйтэй холбоотой байна.

Нэгтгэл судалгаагаар 2023 онд 1,717.2, 2024 онд 1,218.1 сая төгрөгийн төвлөрүүлсэн орлогын дүнг, аймгийн 2023, 2024 онуудын орлогын гүйцэтгэлийн дүнтэй харьцуулахад 2023 онд 171.9, 2024 онд 719.0 сая төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгджээ.

Энэ нь сумаас төвлөрүүлж байгаа торгуулийн орлогыг аль байгууллага, хэлтсээс ямар орлого оруулсныг байгууллага, аж ахуйн нэгжээр нь төрөлжүүлдэггүй, сум тус бүрийн дансны хуулганы нэгтгэл дүнгээр орлогын нийт дүнг гаргаж тайлагнаснаас үүссэн гэж үзэж байна.

Цаашид аймгийн торгуулийн орлого бүрдүүлдэг байгууллагаар нь тухайн жилийн орлогын гүйцэтгэлийг гаргаж, судалгаа боловсруулж ажиллах шаардлагатай байна.


Б.1.4. Торгуулийн орлого бүрдүүлэлт нь аймгийн төсвийн татварын бус орлого аймгийн нийт орлогын дүнд нөлөөлж байна.

Аймгийн татварын бус орлогыг аймгийн ИТХ-ын 2022 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн XII/21 тоот “Булган аймгийн 2023 оны төсөв батлах тухай” тогтоолоор 2849.0, 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн XIX/08 тоот “Булган аймгийн 2024 оны төсөв батлах тухай” тогтоолоор 2024 оны татварын бус орлогыг 1635.0 сая төгрөгөөр тус тус баталжээ.

Үүнээс 2023, 2024 онуудын торгуулийн орлогын баталсан дүн, гүйцэтгэлийн дүнг графикаар харуулбал:

График №1

/сая.төг/



Графикаас харахад торгуулийн орлогын гүйцэтгэл төлөвлөлтөөс 2023 онд 458.9, 2024 онд 398.6 сая төгрөгөөр илүү төвлөрсөн нь өмнөх онуудын торгуулийн үлдэгдэл, зөрчил ихэссэнтэй, торгуулийн орлогын төлөвлөгөөг үнэн зөв, бодитой төлөвлөөгүй, мөн иргэн аж ахуйн нэгж, байгууллага нь хугацаандаа төлөөгүйтэй тус тус холбон үзжээ.

Тус орлогуудыг Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.7-д¹⁹, 23.7.2-т²⁰ заалтуудыг үндэслэн төлөвлөж байгаа ч аймгийн зарлагатай шууд хамраалтай тул аймгийн нийт орлогын дүнд нөлөө үзүүлдэг байна.

Б.2. ХҮҮ, ТОРГУУЛИАС БҮРДСЭН ОРЛОГЫГ ХУУЛЬ, ЖУРМЫН ДАГУУ ХУВААРИЛААГҮЙ БАЙНА.

Б.2.1. Төсвийг хуваарилах эрх бүхий байгууллага бүрэн эрхийн хүрээнд зардлыг төсөвлөж ажиллажээ.

¹⁹ Аймаг, нийслэл болон улсын зэрэглэлтэй хотын төсвийн татварын бус орлого дараах орлогоос бүрдэнэ.
²⁰ орон нутгийн өмчийн эд хөрөнгийг ашигласны төлбөр болон борлуулсны орлого, хүү, торгуулийн орлого.

МУЗЗНДНТУ-ын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2-т²¹, 52 дугаар зүйлийн 52.1-т²², 52.1.2-т²³, 52.1.12-т²⁴, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.4-т²⁵, 6.5.2-т²⁶, 61 дүгээр зүйлийн 61.3-т²⁷, ГХУС тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1-д²⁸ заасан заалтуудыг үндэслэн бүрэн эрхийнхээ хүрээнд аймаг сумдын торгуулийн орлогын гүйцэтгэлээс тухайн онд зарцуулах аймаг, сумдын ГХУСАЗСЗ-ийн зардлыг төлөвлөжээ.

Б.2.2. Хуваарилалтыг хийхдээ ГХУС тухай хуульд заасан аргачлал, тооцоололд нийцүүлэн батлаагүй байна.

Сангийн яамнаас аймгийн ГХУСАЗСЗ, авто замын сангийн суурь зардлыг нийт 2023 онд 1,080.0, 2024 онд 1,108.5 сая төгрөгөөр хянаж ирүүлснийг 2023 онд 42.7, 2024 онд 260.0 сая төгрөгөөр зардлыг тус тус нэмэгдүүлж баталжээ.

ГХУСАЗСЗ-ийн зардлыг тооцож хуваарилахдаа ГХУС тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1-²⁹, 46 дугаар зүйлийн 46.1-д³⁰, Авто замын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.9-д³¹, 25 дугаар зүйлийн 25.2.4-т³², Авто замын санд хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах журмын 3 дугаар зүйлийн 3.5-д³³, 3.5.1-д³⁴, 3.5.2.³⁵ гэсэн хууль, журмын заалтуудыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Б.2.3. Хүү, торгуулийн орлогоос зарцуулах ГХУСАЗСЗ-ийн зардлыг илүү, дутуу тооцож хуваарилсан байна.

Аймаг 16 сум 1 тосгоны хүрээнд торгуулийн орлогыг 2023 онд 1,086.4, 2024 онд 1,538.4 сая төгрөг баталснаас сумд ГХУСАЗСЗ-ийн зардлыг 2023 онд 336.6, 2024 онд 530.1 сая төгрөгөөр тус тус баталсан нь ГХУС тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1 дэх заалтын дагуу³⁶ гэсэн заалтад тусгагдсан хувь хэмжээгээр нарийн тооцож хуваарилаагүй илүү, дутуу хуваарилалт хийж баталсан байна.

Аймаг, сумдын ГХУСАЗСЗ-ийн зардлын 2023, 2024 онуудын хуваарилалтыг хавсралт хүснэгт №3 харуулав.

Цаашид тухайн жилийн торгуулийн орлогоос ГХУСАЗСЗ-ийн зардлыг тооцоолохдоо ГХУС тухай хуульд заасан хувь, хэмжээ аргачлалын дагуу тооцоолж хуваарилах шаардлагатай байна.

²¹ Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолд Хурлын дарга, баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлын тогтоолд Хуралдааны дарга, Хурлын даргыг сонгох, чөлөөлөх тухай тогтоолд тухайн Хуралдаан даргалагч гарын үсэг зурж баталгаажуулна.

²² Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга дараах нийтлэг бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

²³ Тухайн Хурлын хуралдааныг даргалах, гарсан шийдвэрийг ёсчилж баталгаажуулах, хэрэгжилтийг зохион байгуулах

²⁴ хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх,

²⁵ төсвийн захирагч нь төсвийн жилийн дундуур энэ хуулиар олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд тухайн жилийн төсөвтөө өөрчлөлт оруулж, зохицуулалт хийсэн бол гүйцэтгэлийг нь анхны батлагдсан зорилт, хүрэх үр дүнтэй харьцуулж тайлагнадаг байх,

²⁶ төсвийг төлөвлөх, бүрдүүлэх, хуваарилах, тайлагнах үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог хангах.

²⁷ Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны Захирагч энэ хуулийн 61.1-д заасан төлөөлөн хэрэгжүүлэх чиг үүрэг бүрээр санхүүжилтийн хуваарилалт хийх саналаа орон нутгийн төсвийн төслийн хамт бэлтгэж, хуульд заасан хугацааны дотор зохих шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон Зөвлөлд өргөн мэдүүлнэ.

²⁸ Нутгийн захиргааны бүх шатны байгууллага гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар дараах үүрэг хүлээнэ

²⁹ Нутгийн захиргааны бүх шатны байгууллага гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар дараах үүрэг хүлээнэ.

³⁰ “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг тухайн жилд Эрүүгийн хуульд заасны дагуу оногдуулсан торгох ял, Зөрчлийн тухай хуулийн 5.1 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, 5.2, 5.3 дугаар зүйл, 5.4 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, 5.5, 5.6, 5.7 дугаар зүйл, 5.8 дугаар зүйлийн 1, 2, 3, 4, 5 дахь хэсэг, 5.9 дүгээр зүйл, 5.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 5.11 дүгээр зүйлийн 1.5 дахь заалт, 4, 6 дахь хэсэг, 5.12 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 2.1 дэх заалт, 3 дахь хэсэг, 5.16, 5.18 дугаар зүйл, 6.3 дугаар зүйлийн 1, 2, 4 дэх хэсэг, 6.5 дугаар зүйлийн 1, 4, 5, 11, 12, 13 дахь хэсэг, 6.18 дугаар зүйлийн 4, 7 дахь хэсэг, 6.20 дугаар зүйлийн 4, 5, 7, 9 дэх хэсэг, 6.21, 6.22 дугаар зүйл, 7.15 дугаар зүйлийн 8 дахь хэсэг, 8.8 дугаар зүйл, 10.4, 10.8, 10.26, 10.28 дугаар зүйл, 11.15 дугаар зүйлийн 7 дахь хэсэг, 13.5, 14.4, 14.5 дугаар зүйл, 14.6 дугаар зүйлийн 5, 6, 7, 9 дэх хэсэг, 14.7, 15.1 дүгээр зүйл, 15.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 15.6, 15.7, 15.8, 15.9, 15.10, 15.11, 15.18 дугаар зүйл, 15.20 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 15.21 дүгээр зүйл, 15.22 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг, 15.24 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан зөрчилд оногдуулсан торгох шийтгэлийг биелүүлж, төсөвт төвлөрүүлсэн мөнгөн дүнгийн 20-иос доошгүй хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг дүрс бичлэгийн техник, хэрэгсэл, зөрчил болон эрүүгийн хэрэг хянан шалгах байгууллагын мэдээллийн нэгдсэн системийг сайжруулах ажилд, 20-иос доошгүй хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бусад ажилд зориулан дараагийн жилийн төсөвт тусгаж, санхүүжүүлнэ.

³¹ Тухайн жилд улсын авто замын сангийн хөрөнгөөр гүйцэтгэх ажил, зарцуулах хөрөнгийг авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, нийслэл, орон нутгийн чанартай авто замын сангийн хөрөнгөөр гүйцэтгэх ажил, зарцуулах хөрөнгийг аймаг, нийслэлийн Засаг дарга тус тус баталж, хэрэгжүүлнэ.

³² “нийслэл, орон нутгийн авто зам дээр хөдөлгөөний аюулгүй байдлын зөрчил гаргасан, авто замын талаархи хууль тогтоомжийг зөрчсөн этгээдэд ногдуулсан торгууль.”

³³ Авто замын сангийн тухайн жилийн төсвийг төлөвлөх, хуваарилахад дараах зарчмыг баримтална.

³⁴ төсвийн 90-ээс багагүй хувийг Авто замын тухай хуулийн 24.3, 24.4-т тус тус заасан үйл ажиллагаанд,

³⁵ “төсвийн 10 хүртэлх хувийг Авто замын тухай хуулийн 24.5-д заасан үйл ажиллагаанд,

³⁶ “төсөвт төвлөрүүлсэн мөнгөн дүнгийн 20-иос доошгүй хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг дүрс бичлэгийн техник, хэрэгсэл, зөрчил болон эрүүгийн хэрэг хянан шалгах байгууллагын мэдээллийн нэгдсэн системийг сайжруулах ажилд, 20-иос доошгүй хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бусад ажилд зориулан дараагийн жилийн төсөвт тусгаж, санхүүжүүлнэ.”

Б.2.4.Орлогын төлөвлөгөө биелүүлсэн байдал, төвлөрүүлсэн орлогын хэмжээгээр албан хаагчдын ажил дүгнэх үзүүлэлтийг тусгайлан харгалзан үзэж дүгнэдэггүй байна.

Аймгийн хэмжээнд торгуулийн орлогын төвлөрүүлдэг албан байгууллагууд нь торгуулийн хэмжээгээр албан хаагчдыг харгалзан тооцдоггүй, тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, үйл ажиллагааны тайланд дурдаж, тусгайлан дүгнэдэггүй байна.

В. ХҮҮ, ТОРГУУЛИЙН ОРЛОГЫН ЗАРЦУУЛАЛТ ҮР ДҮН БАГА БАЙНА.

В.1. Хүү, торгуулийн орлогыг хөрөнгө оруулалтын шинжтэй арга хэмжээнд зарцуулжээ.

В.1.1. Хүү, торгуулийн орлогын зарим зарцуулалтыг зориулалт бусаар зарцуулсан байна.

Аймгийн төсөвт төвлөрүүлж байгаа торгуулийн орлогоос 16 сум, 1 тосгон, аймгийн ГХУСАЗСЗ-ийн зардалд зарцуулах төсвийг 2023 онд 336.6, 2024 онд 530.0 сая төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 2023 онд 327.8, 2024 онд 533.7 сая төгрөгийг тус тус зарцуулсныг хавсралт хүснэгт №4 харуулав.

Сумдын торгуулийн орлогын нийт баталсан дүнгээс тоног төхөөрөмжийн зардалд зарцуулсан дүнг, эзлэх хувьтай харьцуулж дүгнэхэд ГХУС тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1 дэх заалтыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй, зарим сумд нь тоног төхөөрөмжийн зардлыг төлөвлөөгүй, дунджаар сум тус бүрийн нийт баталсан зардлын 0.5 хувиар тоног төхөөрөмжийн зардлын гүйцэтгэл гарснаар илэрхийлэгдэж байна.

Аймаг сумдын 2023, 2024 онуудад ГХУСАЗСЗ-ийн зардлын нийт гүйцэтгэлээс хамгийн өндөр дүнг эзэлж байгаа зардлын хувийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №5 /сая.төг/

№	Зардлын төрөл	2023 он		2024 он	
		Гүйцэтгэлийн дүн /327.8/	Эзлэх хувь	Гүйцэтгэлийн дүн /533.7/	Эзлэх хувь
1	Тоног төхөөрөмж	84.7	25.8	215.9	40.5
2	Шатахуун	39.7	12.1	43.5	8.2
3	Сургалт	45.8	14	57.2	10.7
4	Цалин урамшуулал	20.1	6.1	44.4	8.3
5	Хөтөлбөр арга хэмжээ	46.7	14.2	53.3	10.0
6	Сурталчилгаа	35.8	11	58.5	11.0
7	Бусад зардалд	55.0	16.8	60.9	11.4
Нийт дүн		327.8	100	533.7	100

Хүснэгтээс харахад нийт зардал өмнөх оноос 205.9 сая төгрөгөөр буюу 38.5 хувиар өссөн үзүүлэлтэй байгаа нь тоног төхөөрөмжийн зардал 2024 онд 190.1 сая төгрөгөөр буюу 88 хувиар өссөн байна.

Тоног төхөөрөмжийн зардалд хамгийн өндөр зардлыг зарцуулсан Булган сумын ИТХ 2023 онд 28.2, 2024 онд 189.9 сая төгрөгийн тоног төхөөрөмжийн худалдан авалтыг хийжээ.

Үүнийг түүвэрлэн үзэхэд хөрөнгө оруулалтын шинжтэй гэрэлтүүлгийн ажилд 20.0, авто машины зардалд 26.0, Цагдаагийн газар, ШШГГ, ШША гэсэн байгууллагуудын дотоод үйл ажиллагаа болон дутагдалтай техник, хэрэгсэл, тавилга эд хогшилд 17.2 сая төгрөгийг зарцуулсан нь ГХУС тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1-д заасан торгуулийн шийтгэврийг биелүүлж, төсөвт төвлөрүүлсэн мөнгөн дүнгийн 20 хувиас доошгүй хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг дүрс бичлэгийн техник, хэрэгслийг зардалд санхүүжүүл гэсэн заалтын дагуу байгууллага тус бүрийн төсөвт оруулсан орлогын дүнгээр тооцож зарцуулаагүй байна.

ГХУСАЗСЗ-ийн зардлаас хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний шинжтэй зардалд зарцуулсан 46.0 сая төгрөгийн зөрчил албан шаардлага хүргүүлж ажиллалаа.

Сумдын олон нийтийн цагдаагийн цалин, урамшууллын зардалд 2023 онд 20.1, 2024 онд 44.4 сая төгрөгийг тус тус олгож, НДШ-ийн зардалд 5.0 сая төгрөг зарцуулсан нь ГХУС тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.5.8-д³⁷ гэсэн заалтын дагуу зарцуулаагүй, нэг удаагийн тэтгэмжийн зардалд 7.1 сая төгрөгийг зарцуулсан боловч тус зардлыг олгохдоо ГХУС тухай 34 дүгээр зүйлийн 34.1-д³⁸, 34.2-т³⁹ гэсэн заалтыг бүрэн хэрэгжүүлээгүй, иргэнийг урамшуулахдаа тухайн хийсэн ажлын үр дүнг дүгнэсэн тайлан, мэдээ, байхгүй, урамшууллын хувийг тооцоогүй зэрэг зөрчлүүд илэрсэнд зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

В.1.2. Зарим сум нь ГХУСАЗСЗ-ийн зардлыг зарцуулахдаа эдийн засгийн ангилал хооронд шилжүүлж, зарцуулжээ.

Аймаг сумдын ИТХ нь 2023, 2024 онуудад ГХУСАЗСЗ-ийн зардлыг зарцуулахад 20 гаруй зардалд зарцуулсан байна.

Эдгээр зардлыг түүвэрлэн шалгахад Булган сумын ГХУСАЗСЗ-ийн 2024 оны зарцуулалтаас 3.1 сая төгрөгийг тус сумын ИТХ-ын тоног төхөөрөмжийн зардалд гүйлгэн зарцуулсан зөрчил илэрсэнд зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

В.1.3. Хүү, торгуулийн орлогоор санхүүжүүлсэн арга хэмжээ нь олон нийтийн сургалт, арга хэмжээнд 2023 онд 95.2, 2024 онд 115.7 сая төгрөгийг тус тус зарцуулжээ.

Аймаг, сумдын торгуулийн орлогоос санхүүжүүлсэн ГХУСАЗСЗ-ийн 2023, 2024 онуудын санхүүжилтээс олон нийтийн хөтөлбөр, арга хэмжээ, сургалт сурталчилгаанд 2023 онд 92.5, 2024 онд 115.7 сая төгрөгийг зарцуулж, нийт санхүүжилтээс 2023 онд 28.2, 2024 онд 21.6 хувийг тус тус эзэлж байна.

Тус санхүүжилтийн зардлыг 2023, 2024 онуудад иргэд олон нийтэд 8-12 төрлийн сургалт, сурталчилгаа, хэлэлцүүлгийн ажилд зарцуулжээ.

Үүнд: Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиар төрийн албан хаагчдад сургалт, нөлөөллийн ажил зохион байгуулах, гэмт хэргийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, “Эрх зүйн баг”-уудын үйл ажиллагааг идэвхжүүлэх зорилгоор тусгай удирдамжийн дагуу уралдаан зарлаж сургалт, нөлөөллийн ажлыг эрчимжүүлэх, Ерөнхий боловсролын сургуулийн “Хүүхдээ

³⁷ олон нийтийн цагдаагийн урамшуулал, эрүүл мэндийн даатгалын зардлыг санхүүжүүлэх

³⁸ Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд идэвхтэй оролцон тодорхой ажил зохиож, үр дүнд хүрсэн хүн, хуулийн этгээдийг урамшуулна

³⁹ “Хуульд өөрөөр заагаагүй бол иргэний өгсөн мэдээллийн дагуу зөрчилд 200 хүртэл нэгжээр торгох шийтгэл оногдуулсан бол иргэнд тухайн шийтгэлийн 20 хүртэл хувьтай тэнцэх хэмжээний, 200-аас дээш нэгжээр торгох шийтгэл оногдуулсан бол 10 хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшуулал олгож болно.

сонсьё” хүүхдийн чуулган зохион байгуулах, Бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдийн орчин нөхцөл, гэр бүлийн харилцаа, амьдралд дүн шинжилгээ хийх, Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээ, сургалт, сурталчилгаа, Зам тээврийн осол, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээ, сургалт, сурталчилгаа, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтэд хяналт тавих, хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээ, сургалт, сурталчилгаа зэрэг олон сургалт арга хэмжээнүүдийг зохион байгуулсан байна.

В.1.4. Нийгэм, эдийн засагт нөлөө үзүүлэхүйц арга хэмжээнүүд хийгдсэн гэж дүгнэгдэж байна.

Аймгийн ИТХ-ын ГХУСАЗСЗ нь тухайн жил тутам хийгдсэн ажлын мэдээ, тайлан сумдын ИТХ-аас авч, ГХУС тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.5-д⁴⁰ гэсэн заалтын дагуу ажлын тайланг хүргүүлж, иргэд олон нийтэд хийсэн сургалт, арга хэмжээний үр ажлын үр дүнг тооцон ажиллажээ.

Тухайлбал: Сургуулийн сурагчдыг “Эрсдэлээс сэргийлэх, гэр бүлийн гишүүдтэйгээ үнэгүй холбоо барих нөхцөлийг бүрдүүлж аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг, Ерөнхий Боловсролын 19 сургуульд “Итгэлтэй утас”-ыг салбар зөвлөлийн хөрөнгөөр суурилуулах ажил зохион байгуулснаар сургуулийн сурагчид эцэг, эхтэйгээ болон шаардлага үүссэн нөхцөлд 2 минут үнэгүй ярих боломжийг бүрдүүлсэн байна.

Мөн “Хүүхэд хамгаалалд бидний оролцоо” сэдэвт ЭССЭ бичлэгийн уралдааныг жил бүр зохион байгуулснаар хүүхдийн оролцоо нэмэгдэж далд хэлбэрээр бий болж буй аливаа гэмт хэрэг, зөрчлийг ил тод гаргаж өгсөн, Хүүхэд хамгааллын түр өрөөг иж бүрэн тохижуулсан нь эрүүл мэндийн болон сэтгэл санааны хохиролд өртсөн хүүхдүүдэд нэн таатай орчныг бий болгож, байр 1 нэмэгдсэн, Булган аймгийн хэмжээнд сумдын ГХУСАЗСЗ-д камержуулалтын үйл ажиллагааг сайжруулах зөвлөмж чиглэл хүргүүлэн ажилласнаар сургууль, цэцэрлэгийн орчинд камержуулалтын шинэчлэлт, шинээр камержуулалтын ажлыг зохион байгуулж, сумдын багийн цэцэрлэг, сургуулийн орчинд тус ажлууд хийгджээ.

Шинэлэг ажлаас 2024 онд зохион байгуулсан ТЕГ-ын Булган аймаг дахь хэлтэстэй хамтран Хүн амын удмын сангийн аюулгүй байдлыг хангах ажлыг эрчимжүүлэх, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болзошгүй иргэдийг тогтоох, ХДХВ буюу ДОХ-ын халдвараас урьдчилан сэргийлэх мэдлэг мэдээллийг олон нийтэд түгээх, бэлгийн цөөнх иргэдийг бүртгэлжүүлэх, хяналт тавих ажлыг зохион байгуулсан нь үр дүнтэй ажил хийгдсэн гэж дүгнэжээ.

Эдгээр хийгдсэн ажлуудаас үзэхэд 2023, 2024 онуудад 2-3 ажил нь давтагдаж байгаа ч шинээр зохион байгуулсан арга хэмжээнүүд нь үр дүн, үр нөлөө үзүүлснээр илэрхийлэгдэж байгаа нь олон нийтийг хамарсан үр нөлөөтэй ажлууд хийгдсэн гэж дүгнэгдэж байна.

В.2. ХҮҮ, ТОРГУУЛИЙН ОРЛОГЫН ЗАРЦУУЛАЛТЫГ ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХҮРЭЭНД МЭДЭЭЛЖ БАЙГАА Ч ГХУСАЗСЗ НЬ ОЛОН НИЙТЭД ХИЙГДСЭН АЖЛЫН ТАЙЛАНГАА ТАЙЛАГНАХ АЖИЛ НЬ ДУТМАГ БАЙНА.

В.2.1. Хүү, торгуулийн орлогын зарцуулалтыг шилэн дансанд мэдээлж ажиллажээ.

Аймгийн ТЕЗ, сумдын ТТЗ нь тухайн жил бүрийн орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлого, гүйцэтгэлийн мэдээг шилэн дансны тухай хуулийн 6 дугаар

⁴⁰ “Салбар болон Дэд зөвлөл түүнчлэн энэ хуулийн 13.1.2, 13.1.3-т заасан этгээд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын тайланг Зохицуулах зөвлөлд жил бүр ирүүлнэ. Зохицуулах зөвлөл улсын хэмжээнд гэмт хэргийн нөхцөл байдал, түүнээс урьдчилан сэргийлэх талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, цаашдын төлөв байдлын талаар нэгдсэн тайланг жил бүр Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд, хоёр жил тутамд Улсын Их Хуралд танилцуулна.”

зүйлийн 6.1.2-т⁴¹, 6.2.5-д⁴² гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж шилэн дансны сайтад улсын төсөв болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл гэсэн цэсэд сар бүр мэдээлж ажиллажээ.

В.2.2. Эрх бүхий байгууллага нь хүү, торгуулийн орлогын зарцуулалтын тайлан, мэдээллийг шилэн дансны сайтад болон өөрийн байгууллагын самбараар мэдээлж ажиллажээ.

ГХУСАЗСЗ-ийн зарцуулалтыг сар бүр Аймгийн ИТХ болон сумдын ИТХ-ын шилэн дансны сайтын төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хөтөлбөр зориулалт, тушаал шийдвэр, төсөв хөрөнгөтэй холбоотой анхан шатны баримтыг “бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр” цэсэд, мөн байгууллагын шилэн данс самбарт, гүйцэтгэлийн мэдээ, тайланг цаасан хэлбэрээр, цаг хугацаанд нь тус тус мэдээлж ажилласан байна.

В.2.3. Иргэд, төрийн бус байгууллага, хяналтын зөвлөл зэрэг оролцогч талууд хүү, торгуулийн орлогын зарцуулалттай холбоотой асуудлыг зарим сумдын ГХУСАЗСЗ нь ил тод байдалд үнэлгээ өгч, санал хүргүүлэх, тайлагнах ажил дутмаг хийгдсэн байна.

Аймаг, сумдын ИТХ-ын дэргэдэх ГХУСАЗСЗ-ийн дарга, гишүүдийг сонгохдоо ГХУС тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т⁴³ гэж заасны дагуу төрийн байгууллагын ажилчид сонгогдон ажиллаж байна.

Үүнд: Аудитын явцад түүвэрлэлтээр аймгийн ИТХ-ын ГХУСАЗСЗ нь 1 дарга, 14 гишүүнтэй, Булган сумын ИТХ-ын ГХУСАЗСЗ нь 1 дарга, 10 гишүүнтэй, Тэшиг сумын ИТХ-ны ГХУСАЗСЗ нь 1 дарга, 16 гишүүнтэйгээс 1 иргэн бусад нь төрийн байгууллагын төлөөлөл, ажилчид хамрагджээ.

Тухайлбал: Аймгийн шүүхийн Ерөнхий шүүгч, аймгийн ЗДТГ-ын ХЭЗХ-ийн дарга, Цагдаагийн дарга, ТЕГ-ийн Булган аймаг дахь хэлтсийн дарга, ОБГ-ын дарга, ХГБХХ-ын газрын дарга, Боловсролын газрын дарга, БОГ-ын дарга, ЭМГ-ын дарга нар зөвлөлийн гишүүнээр сонгон ажиллуулж байна.

Сумдын ИТХ-ын ГХУСАЗСЗ нь тухайн оны хүү, торгуулийн орлогын хуваарилалт, зарцуулалттай холбоотой тайлан мэдээг жилд 1 удаа аймаг, сумдын ИТХ-д тайлагнаж, хагас бүтэн жилээр сумдын ИТХ-ын ГХУСАЗСЗ-ийн санхүүжилт, зарцуулалт, хийгдсэн ажлын тайлан мэдээг аймгийн ИТХ-ын ГХУСАЗСЗ-д нэгтгүүлж ажилладаг байна.

ГХУСАЗСЗ-үүд нь ГХУС тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т⁴⁴ гэж заасны дагуу улирал тутам хуралдсан ч зарим сумд нь хуралдаагүй, асуудал хэлэлцэх үед хуралддаг, хагас бүтэн жилээр хуралдаж зарцуулалттай холбоотой болон цаашид анхаарах асуудлаа хэлэлцдэг гэсэн тайлбар өгч байгаа ч зарим сумдын ГХУСАЗСЗ нь сумынхаа ИТХ-д тайлангаа танилцуулаагүй, олон нийтээс санал авах ажил хийгдээгүй байна.

⁴¹ “хагас жилийн төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор, өмнөх оны төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, сар, улирлын гүйцэтгэлийг дараа сарын 08-ны өдрийн дотор,

⁴² “улсын төсөв болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлого, тэдгээрийн задаргаа;

⁴³ “Зохицуулах зөвлөлийн орон тооны ажлын албаны удирдах болон гүйцэтгэх албан тушаалтан нь төрийн албан хаагч байх бөгөөд албан тушаалын ангилал, зэрэглэлийг төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно.”

⁴⁴ “Зохицуулах болон Салбар зөвлөл нь улиралд нэгээс доошгүй удаа хуралдах бөгөөд хурлын шийдвэр нь тогтоол, зөвлөмж, мэдэгдэл хэлбэртэй байна.”

Тухайлбал: Баян-Агт, Тэшиг сумын ГХУСАЗСЗ нь 2023, 2024 онд, Булган сумын ГХУСАЗСЗ нь 2024 онд хийсэн ажлаа тайлагнаагүй байна.

Булган сумын ИТХ-ын ГХУСАЗСЗ нь 2023 онд 5 удаа хуралдаж, хуралдаанаар 2 асуудлыг хэлэлцэж шийдвэрлэсэн байна.

Үүнд: Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах талаар Булган сумын хатуу хучилттай автозамын үзэгдэх орчин хязгаарлагдсан /Миний голомт, 1 дүгээр сургуулийн ар тал, Зүүн түрүү, бага сургууль/ гэсэн 4 уулзваруудад гүдгэр толь байршуулж, гэрэлтүүлгийн ажлын зураг төсөв, санхүүжилттэй холбоотой асуудлыг шийдвэрлэжээ.

Аудитын явцад түүвэрлэлтэд хамрагдсан 7 сумдын ГХУСАЗСЗ-ийн мэдээлсэн, ирүүлсэн баримттай танилцаж дүгнэхэд зарим сумдын ГХУСАЗСЗ нь ажлаа гүйцэтгэж байгаа ч олон нийтэд мэдээлж, үнэлгээ, санал авах, тайлагнах ажил нь дутмаг хийгдсэн байна гэж дүгнэлээ.

Г.1. ХҮҮ ТОРГУУЛИЙН ОРЛОГЫН НЭГДСЭН БҮРТГЭЛ МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМ БАЙХГҮЙ, НОГДУУЛСАН ТОРГУУЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ ХИЙХ НӨХЦӨЛ БҮРДЭЭГҮЙ БАЙНА.

Г.1.1. Хүү, торгуулийн орлого бүртгэлийн нэгдсэн бүртгэл мэдээллийн системийг бүрэн нэвтрүүлээгүй, мэдээллийн сан бий болоогүй байна.

Зөрчил, торгууль, шийтгэлийн мэдээллийг нэгтгэн бүртгэх, байгууллага хооронд мэдээлэл солилцох, орлого бүрдүүлэлтийн хэрэгжилтийг хянах нэгдсэн бүртгэл, хяналтын систем бий болоогүй байна. Байгууллага бүр өөрийн салбарын бүртгэлийн программ хангамжийг тус тусдаа ашигладаг, зарим газарт бүртгэлийн цахим систем огт ашигладаггүй байна.

- Цагдаагийн бэлэн бус торгууль “Цагдаагийн байгууллагын мэдээллийн систем”-д торгуулийн мэдээлэл бүртгэгдэж, ЦЕГ-ийн хэмжээнд нэгдсэн сан үүсдэг,
- Прокурорын байгууллагын зөрчлийн бүртгэл мэдээллийн сан /E-zurchil.mn/ систем ашиглаж байна.
- Татварын газар нь Tais системээр орлогыг бүртгэж, ТЕГ-ын Татвар хураалтын удирдлагын газар нэгдсэн сан үүсгэдэг.
- Хуучин мэргэжлийн хяналтын байцаагч нар тус тусын эрхээр нэвтэрч <http://shilenkhyanalт.gov.mn> цахим системээр торгууль бүртгэж биелэлтийг тооцож байна.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газар татан буугдсанаар системийн үндсэн хэрэглэгч, зохион байгуулах бүтэц үгүй болж, салбарын хяналтыг нэгдсэн бодлого, арга зүйгээр хангах үүрэгтэй байгууллага, албан тушаалтан тодорхойгүй болсон байна.

Нэгдсэн системгүйгээс тухайн эрх бүхий байгууллагын тогтоосон торгуулийн орлогыг аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсийн орлогын мэргэжилтэн төлөвлөлт, орлогын гүйцэтгэл зэрэгт дүн шинжилгээ хийх нөхцөл боломж хүндрэлтэй байна.

Г.1.2 Шийтгэврийн мэдээлэл нь нэгдсэн бүртгэлгүйгээс зарим төрлийн торгуулийг цахимаар төлөх нөхцөл хангагдаагүй байна.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 7.5 дугаар зүйлд зааснаар зөрчил гаргасан иргэн, хуулийн этгээд торгуулийг бэлэн болон бэлэн бус хэлбэрээр төлөх зохицуулалттай хэдий ч, эрх бүхий албан тушаалтнуудын шийтгэврийн мэдээлэл нь нэгдсэн бүртгэлд бүрэн нэгтгэгддэггүйгээс Замын хөдөлгөөний зөрчлийн торгуулиас бусад төрлийн торгуулийг цахимаар төлөх нөхцөл хангагдаагүй байна.

Замын хөдөлгөөний зөрчлийн торгуулийг төлөх боломжийг хангах зорилгоор **e-Mongolia, SmartCar, Гэрэгэ киоск**, банкны интернэт болон мобайл банкны аппликейшн зэрэг төлбөрийн цахим сувгууд өргөн ашиглагдаж байна. Бэлэн бус торгуулийн төлбөрийг төлөлтийг үзэхэд дараах байдалтай байна

Хүснэгт № 6 Замын хөдөлгөөний зөрчлийн торгуулийн төлөлт, төлбөрийн системийн ангилал

Төлбөрийн систем	2023		2024	
	Төлөгдсөн торгууль			
	Тоо	дүн	Тоо	дүн
E-barimt	128	4.8	30	0.60
E-mongolia	5751	217.8	8786	189.3
Гэрэгэ	10518	349.5	8314	198.3
Mostmoney	28	0.8	58	1.3
smartcar	3678	134.0	4796	101.6
Toki	399	13.0	638	13.7
Арилжааны банкаар	10771	382.4	8499	180.5
Дүн	31,273.00	1,102.4	31,121.00	685.3

Замын цагдаагийн байгууллагаас ногдуулсан торгуулийн мэдээлэл тус бүрийг дахин давтагдашгүй дугаар, бар кодоор тэмдэглэж, төлөлтийн явцад хяналт тавих, торгуулийн биелэлтийг тооцох нөхцөл бүрдүүлж, цагдаагийн байгууллагын хувьд системийн хэрэгжилтийг хангалттай хэмжээнд хэрэгжүүлж чадсан байна. Харин УИХ-аас 2023 оны 12 дугаар сарын 07-ний өдрийн “Зөрчлийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” хуульд шийтгэлийн хэмжээг хөнгөрүүлэх, нэмэгдүүлэх үндэслэлийг баталсантай холбогдуулж системд хөгжүүлэлт хийгдээгүй байна.

Бусад торгууль ноогдуулдаг эрх байгууллагуудын хувьд төрийн сангийн дансны хуулга авч тулган баталгаажуулалт хийсэн дараа л торгууль төлөгдсөн эсэхийг мэдэж байна нь торгууль барагдуулах, хянах, мэдээлэхэд хүндрэл учруулж байна.

Г.1.3. Торгуулийн орлогыг хугацаанд нь бүрэн төвлөрүүлэх, дараагийн шатны арга хэмжээг цаг алдалгүй авах зэрэг боломжууд бүрдсэн байна.

Цагдаагийн байгууллага, татвар, мэргэжлийн хяналтын байгууллагын ашиглаж байсан “Шилэн хяналт” нэгдсэн мэдээллийн системийг ашиглаж байгаа бөгөөд тус системээрээ мөн хяналтыг гүйцэтгэдэг байна. Системээр хяналтыг хэрэгжүүлснээр торгуулийг төлөгдсөн эсэхийг хянах, торгуулийн орлогыг хугацаанд нь бүрэн төвлөрүүлэх, дараагийн шатны арга хэмжээг цаг алдалгүй авах зэрэг боломжууд бүрдсэн байна.

2023 онд нийт 18 байгууллага 2002.2 сая төгрөгийн торгууль, 2024 онд 17 байгууллагын эрх бүхий албан тушаалтан 1750.9 сая төгрөгийн торгууль ногдуулсан байна. Торгуулийн ногдуулалт, төлөлтийг байгууллага тус бүрээр харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт № 7 Торгууль орлогыг байгууллага бүрээр харуулбал

№	Байгууллага	2023			2024		
		Ногдуулсан	Төлсөн	Зөрүү	Ногдуулсан	Төлсөн	Зөрүү
1	Булган аймгийн Боловсролын газар	-	-	-	0.0	0.0	-
2	ХХААГ	1.0	1.0	-	-	-	-
3	Мал эмнэлгийн газар	0.3	0.3	-	2.0	2.2	(0.2)
4	Булган аймгийн НДГ	1.0	0.8	0.3	-	-	-
5	Булган аймгийн ОБГ	0.3	0.3	-	5.6	5.5	0.1
6	Булган аймгийн ХХҮГ	3.5	3.5	-	2.0	1.0	1.0
7	Хөгнө тарнын байгалын цогцолборт газрын хамгаалалтын захиргаа	5.5	4.6	0.9	0.5	-	0.5
8	Булган аймаг БОГГазар	20.2	21.8	(1.6)	36.4	38.3	(1.9)
9	Улсын бүртгэлийн хэлтэс	5.8	5.8	-	11.0	11.0	-
10	Булган аймгийн Авто тээврийн төв	14.6	14.6	-	8.4	8.4	-
11	Булган аймгийн татварын газар	77.4	57.5	19.9	144.8	87.2	57.6
12	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар	8.9	8.9	-	18.0	18.3	(0.3)
13	Эрүүл мэндийн газар	1.3	1.3	-	3.1	3.1	-
14	Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар	62.2	47.8	14.4	55.8	35.8	20.0
15	Цагдаагийн газар	1,689.1	1,482.2	206.9	1,378.7	952.7	426.0
16	Хүүхэд гэр бүлийн хөгжил хамгааллын газар	-	-	-	0.6	0.6	-
17	Аймгийн ЗДТГ	84.8	62.6	22.2	79.2	49.2	30.0
18	Аймгийн ЗДТГ СТСХ	24.6	2.6	22.0	4.4	4.4	-
19	Цэргийн штаб	-	-	-	0.1	0.1	-
20	Хилийн цэргийн 0286	1.8	1.8	-	0.2	0.2	-
	Дүн	2,002.2	1,717.2	285.0	1,750.9	1,218.0	533.0

Системийн хяналтаас гадна хууль эрхзүйн орчинд дараах зохицуулалтууд орсон нь ноогдуулсан торгуулийг хугацаанд нь биелүүлэх нэг хөшүүрэг бий болсон байна. Тухайлбал: УИХ-аас 2023 оны 12 дугаар сарын 07-ний өдрийн “Зөрчлийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” хуульд шийтгэлийн хэмжээг хөнгөрүүлэх, нэмэгдүүлэх үндэслэлийг баталсан, мөн ноогдуулсан торгуулийг удаа дараа төлөөгүй тээврийн хэрэгсэл эзэмшигчийн тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хасах, төрийн байгууллагуудын холбогдох үйлчилгээгээр хангахгүй байх зэрэг зохицуулалтуудыг хийсэн нь Замын цагдаагийн эрх бүхий албан хаагчдын ноогдуулсан торгуулийн орлого бүрдүүлэлтийн хувийг өсгөхөд нөлөөлөх хуулийн нэмэлт өөрчлөлт орсон байна.

Гэвч дээрх хүснэгтээс харахад цагдаагийн байгууллагын аудитад хамрагдсан хугацааны ногдуулалт, төлөлтийг харьцуулан харахад өмнөх жилд нийт

ногдуулалтын 87.7 хувь нь бүрэн барагдаж байсан бол, 2024 онд 69.1 хувь болж буурсан байна.

Зөрчил, торгуулийн мэдээллийн нэгдсэн цахим систем бий болоогүй, зөвхөн цагдаагийн байгууллагын хувьд зөрчил, төлөлтийн цахим системийг хөгжүүлж, ашиглаж байна.

Аудитын явцад хийсэн шалгалтаар торгуулийн орлогын бүрдүүлэлтэд төвлөрсөн, системтэй хяналт тавих тогтолцоо бүрдээгүй, бие даасан хяналтын систем үйл ажиллагаа байхгүй торгууль тогтоосон эрх бүхий албан тушаалтан нь л тухайн торгуулийг барагдуулдаг нь орлогын бүрдүүлэлтэд сөрөг нөлөө үзүүлж байна.

Иймд торгуулийн орлого бүрдүүлэлтийг хянах төвлөрсөн, ил тод, бие даасан хяналтын тогтолцоог бий болгох шаардлагатай байна.

Г.2. ХҮҮ, ТОРГУУЛИЙН ОРЛОГЫН НОГДУУЛАЛТАД, ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАН ХЯНАЛТ ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙГАА Ч БҮРДҮҮЛЭЛТЭД ТАВИХ ХЯНАЛТ СУЛ БАЙНА.

Г.2.1. Хугацаа хэтэрсэн торгуулиас ШШГГ албадан гүйцэтгүүлснээс өөр зохион байгуулалтын арга хэмжээ аваагүй байна.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 7.4 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт “зөрчлийн үр дагаврыг арилгах тухай эрх бүхий албан тушаалтны даалгаврыг зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээд биелүүлээгүй, эсхүл энэ арга хэмжээний зардлыг тогтоосон хугацаанд төлөөгүй бол шүүхэд хүсэлт гаргаж, шүүхийн шийдвэр гүйцэтгэх журмаар албадан гүйцэтгүүлнэ”, 9.3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “зөрчлийн үр дагаврыг арилгах тухай эрх бүхий албан тушаалтны даалгаврыг зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээд биелүүлээгүй, эсхүл энэ арга хэмжээний зардлыг тогтоосон хугацаанд төлөөгүй бол шүүхэд хүсэлт гаргаж, шүүхийн шийдвэр гүйцэтгэх журмаар албадан гүйцэтгүүлнэ” гэсэн зохицуулалттай.

Аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад 2023-2024 онуудад нийт 48.4 сая төгрөгийн 141 зөрчлийн торгуулийг албадан гүйцэтгүүлэхээр хүргүүлснээс 100.0 хувьтай хэрэгжсэн байна.

Хүснэгт № 8 ШШГГ-аар албадан гүйцэтгүүлсэн торгууль

№	Байгууллагын нэр	/сая төгрөг/ Торгууль	
		Тоо	Дүн
1	Булган аймаг дахь Газрын харилцаа бариллага байгуулалтын газрын эрх бүхий албан тушаалтны	2	10.0
2	Булган аймаг дахь Цагдаагийн газрын эрх бүхий албан тушаалтны	107	28.3
3	Булган аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газрын байгаль орчны хяналтын эрх бүхий албан тушаалтны	2	5.05
4	Булган аймаг ЗДТГ төрийн сангийн улсын байцаагчийн	1	0.04
5	Булган аймгийн онцгой байдлын газар	26	3.5
6	Булган аймгийн татварын газрын эрх бүхий албан тушаалтны	3	1.5
	Дүн	141.0	48.4

Дээрх шүүхийн шийдвэрээр албан гүйцэтгүүлсэн торгууль нь замын хөдөлгөөний дүрэм зөрчиж бусдын эрүүл мэнд, хөрөнгөд хохирол учруулсан, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон, иргэн, хуулийн этгээд галын аюулгүй байдлыг хангах үүргээ биелүүлээгүй, барилга байгууламжид гал унтраах тоног төхөөрөмж, анхан шатны багаж хэрэгсэл, бодис, материал байрлуулах журам зөрчсөн зэрэг зөрчлүүдийг шүүхээр шийдвэрлүүлсэн байна.

Бэлэн бус торгуулийн 2022-2024 оны ногдуулалт төлөлтийг үзэхэд үлдэгдэл нийт 1,069.4 сая төгрөг, зөвхөн 2024 оны төлөгдөөгүй торгууль 425.9 сая төгрөг байна.

Г.2.2. Торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад тусгайлан хяналт хэрэгжүүлээгүй, хууль журмын дагуу явцын хяналтууд хийгдэж байна.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай 7.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “эрх бүхий албан тушаалтан шийтгэл оногдуулсан, албадлагын арга хэмжээ авсан шийдвэрийнхээ биелэлтийг хариуцна”, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зориулан орон нутгийн төсвөөс санхүүжилт олгох, зарцуулах, тайлагнах журмын 3 дугаар зүйлийн 12-т “гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлын зарцуулалтад тухайн шатны Хурал, санхүүгийн хяналт шалгалтын байгууллага хяналт тавина” гэж заасан байна.

Цагдаагийн ерөнхий газрын Дотоод хяналт аюулгүй байдлын газар нь аймгийн Цагдаагийн газрын 2024 оны жилийн эцсийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийхдээ замын цагдаагийн цахимаар торгосон байдал, торгуулийн орлогын төлөлт дээр хяналт хийдэггүй бөгөөд үндсэн үйл ажиллагааны хяналт шалгалтыг хийсэн байна.

Зөрчил шалган шийдвэрлэх ЭБАТ нь зөрчлийн хэрэг үүсгэсэн, хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэсэн даруй прокурорын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэхээр хуульчилсан. Иймд Прокурорын байгууллагаас зөрчлийн хэрэг бүрдүүлэлтэд хяналт хэрэгжүүлэхдээ торгуулийн биелэлтийг хянадаг нь орлогын бүрдүүлэлтэд ихээхэн нөлөөг үзүүлж байна. Прокурорын байгууллагаас хяналтыг хэрэгжүүлэх нь иргэдийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, шударга ёсыг хангах, ЭБАТ-ы хариуцлагыг нэмэгдүүлэх зэрэг эерэг үр дагаврыг бий болгож байна.

Г.2.3. Торгуулийн орлого төвлөрүүлдэг байгууллагууд нь дотоод хяналт хэрэгжүүлээгүй байна.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 2.3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.1-т “зөрчлийн хэрэг бүртгэлтийг удирдах албан тушаалтан дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг зохион байгуулалт, мэргэжлийн удирдлагаар хангах” гэж заасан байдаг.

Шийтгэлийн торгуулийн орлогыг тухайн шийдвэрийг ногдуулсан ЭБАТ бүрэн хариуцаж зөрчлийн биелэлтийн хуудсыг хэрэг бүртгэлд хавсаргадаг бөгөөд шууд харьяалах дээд шатны албан тушаалтан тухай бүр хяналтыг хэрэгжүүлэн шаардлагатай арга зүйгээр ханган ажиллаж байна.

Хүү, торгуулийн орлогын төлөвлөлт, бүрдүүлэлт, зарцуулалтад аймгийн төсвийн ерөнхийлөн захирагч, санхүү төрийн сангийн хэлтэс, сумдын санхүүгийн алба нь санхүүгийн гүйцэтгэлийг хянах чиг үүрэгтэй байна.

Дээрх хяналт тавих эрх бүхий байгууллага, албан тушаалтнууд нь орлого бүрдүүлэлтийг зөвхөн орж ирсэн орлогын гүйцэтгэлээр хянаж байгаа бөгөөд торгуулийн ногдуулалтын хэмжээ, хугацаа хэтрэлт, төлөлтийн явцад нэгдсэн хяналт тавих тогтолцоо бүрдээгүй, хяналт сул байна.

Г.2.4. Аудитын хамрах хугацаанд иргэд, төрийн бус байгууллага, хяналтын зөвлөл зэрэг хөндлөнгийн байгууллагуудаас хяналт хэрэгжүүлээгүй байна.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1-т “төрийн бүх шатны байгууллага, албан тушаалтан гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулах, түүнийг хэрэгжүүлэх явцад олон нийтийн оролцоог хангана”, 38.2.6-т “гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын төсвийн зарцуулалтад олон нийтийн оролцоо, хяналтыг бий болгох” гэж заасан байна.

Аудитын хамрах хугацаанд иргэд, төрийн бус байгууллага, хяналтын зөвлөл зэрэг хөндлөнгийн байгууллагуудаас хяналт хэрэгжүүлээгүй байна.

ДҮГНЭЛТ:

Аудитаар нийт 55.2 сая төгрөгийн зөрчил илрүүлснээс 46.0 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 9.2 сая төгрөгийн зөрчилд 5 зөвлөмж хүргүүлж ажиллалаа.

- ✓ Хүү, торгуулийн орлогыг бодитой тооцож, төлөвлөх боломжгүй байна.
- ✓ Торгуулийн орлогыг төлөвлөхдөө орлого бүрдүүлдэг байгууллагуудын зөрчлийн тоо хэмжээ, хэрэгжилт зэрэг суурь судалгаа мэдээлэл, дүн шинжилгээг хийгээгүй, зөвхөн өмнөх оны гүйцэтгэлд үндэслэн төлөвлөсөн байна.
- ✓ Авто замын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2.4 дэх заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.
- ✓ Хүү, торгуулийн орлоготой холбоотой зарим хуулийн заалтууд хоорондоо нийцэхгүй байна.
- ✓ Торгууль тогтоосон зөрчилтэй асуудлыг аймгийн Прокурорын байгууллагаар хянуулж ажилласан байна.
- ✓ Хүү, торгуулийн орлогыг төлөвлөхдөө өмнөх оны гүйцэтгэлээр төлөвлөж Сангийн яаманд хүргүүлжээ.
- ✓ 2023-2024 онд ногдуулсан торгуулийн орлогын гүйцэтгэл 819.6 сая төгрөгөөр дутуу төвлөрүүлсэн байна.
- ✓ 16 сум 1 тосгоны хүрээнд торгуулийн орлогоос ГХУСАЗСЗ-ийн зардлын хуваарилалтыг төлөвлөж, батлахдаа ГХУС тухай хуульд заасан хувь хэмжээгээр тооцож хуваарилаагүй байна.
- ✓ Торгуулийн орлогын төлөвлөгөө, төвлөрүүлсэн орлогын хэмжээгээр албан хаагчдын ажил дүгнэх үзүүлэлтийг тусгайлан харгалзан үзэж дүгнэдэггүй байна.

- ✓ ГХУСАЗСЗ-ийн нийт баталсан зардлын 0.5 хувиар тоног төхөөрөмжийн зардлын гүйцэтгэл гарснаар илэрхийлэгдэж байна.
- ✓ ГХУСАЗСЗ-ийн зардлыг зарцуулахдаа эдийн засгийн ангилал хооронд шилжүүлэн зарцуулжээ.
- ✓ Олон нийтийн сургалт, арга хэмжээнд 2023 онд 95.2, 2024 онд 115.7 сая төгрөгийг тус тус зарцуулжээ.
- ✓ Хүү, торгуулийн орлогын гүйцэтгэлийг байгууллага тус бүрээр нэгтгэн гаргаагүй, зөвхөн дансны хуулганы нийт дүнгээр нэгтгэсэн байна.
- ✓ Торгуулийн орлогын төлөвлөлт, гүйцэтгэлийн мэдээг шилэн дансны сайтад тухай бүр мэдээлжээ.
- ✓ Зарим сумын ГХУСАЗСЗ нь олон нийтэд хийгдсэн ажлын тайлангаа тайлагнах, санал авах ажил дутмаг хийгдсэн байна.
- ✓ Хүү, торгуулийн орлого бүртгэлийн нэгдсэн бүртгэл мэдээллийн системийг бүрэн нэвтрүүлээгүй, мэдээллийн сан бий болоогүй байна.
- ✓ Шийтгэврийн мэдээлэл нь нэгдсэн бүртгэлгүйгээс зарим төрлийн торгуулийг цахимаар төлөх нөхцөл хангагдаагүй байна гэж дүгнэлээ.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд

Аймгийн ИТХ-ын ГХУСАЗСЗ-ийн дарга Ж.Ганболд танаа:

1. ГХУС тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дэх заалтын бүрэн хэрэгжүүлж, ГХУСАЗСЗ-ийн хэрэгжилтийн тайланг олон нийтэд мэдээлж, үнэлгээ, санал авах, ажлыг зохион байгуулж ажиллах.
2. ГХУС тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1, 34.2, 46 дугаар зүйлийн 46.5.8 дахь заалтуудыг бүрэн хэрэгжүүлж сумдын ИТХ-ын ГХУСАЗСЗ-д чиглэл өгч ажиллах.
3. ГХУСАЗСЗ-ийн зардлыг баталсан төсвийн дагуу зарцуулж ажиллахыг сумдын ИТХ-ын ГХУСАЗСЗ-д үүрэг өгч ажиллах.

Аймгийн Засаг дарга Д.Пүрэв-Очир, СТСХ-ийн дарга Б.Ариунболд нарт:

1. Торгуулийн орлогын гүйцэтгэлийг тайлагнахдаа сумдын торгууль шийтгэвэр тогтоосон байгууллагын төлөвлөлт, гүйцэтгэлээр судалгааг гаргаж ажиллах.
2. Торгуулийн орлогоос ГХУСАЗСЗ-ийн зардлыг хуваарилахдаа ГХУС тухай хуулийн 46.1 дэх заалтад заасан хувь хэмжээг баримтлан, төлөвлөж ажиллах.

Санал:

Аймагт төвлөрч байгаа торгуулийн орлогоос цагдаагийн байгууллагын торгууль, шийтгэврийн хуудсаар болон бэлэн бусаар торгосон орлогууд дийлэнх хувийг эзэлжээ. Үүнээс авто замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчсөн торгуулийн орлого ихэнх хувийг эзэлж байна.

Тус орлогыг төвлөрүүлэхдээ авто замын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2.4 дэх хэсэгт⁴⁵ гэж заасны дагуу тус зөрчлөөр илэрсэн торгуулийн орлогыг автозамын сангийн дансанд төвлөрүүлэхгүйгээр аймгийн хүү, торгуулийн орлогын дансанд төвлөрүүлэхээр системчлэгдсэнийг холбогдох газар нь уламжилж, авто замын тухай хуульд заасны дагуу зохицуулах арга хэмжээг авч ажиллах саналыг хүргүүлж байна.

⁴⁵ “нийслэл, орон нутгийн авто зам дээр хөдөлгөөний аюулгүй байдлын зөрчил гаргасан, авто замын талаарх хууль тогтоомжийг зөрчсөн этгээдэд ногдуулсан торгууль”

“Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт”

Хавсралт №1

Аймгийн 2023, 2024 онуудын торгуулийн үлдэгдэлтэй иргэн, байгууллагын нэрсийн жагсаалт

/сая.төг/

№	Байгууллагын нэрс	Зөрчлийн үндэслэл	Иргэний нэр	Аж ахуйн нэгж	2023 оны төлөгдөөгүй үлдэгдэл	2024 оны төлөгдөөгүй үлдэгдэл
1	Булган аймгийн НДГ	Зөрчлийн тухай хуулийн 10.17-3-р зүйл	Ня-бо Б.Долгорсүрэн	"Баян нутгийн илч" ХХК	0.2	
2	ХХҮГазар	Зөрчлийн тухай тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 2.1.2 дахь заалт		"Хастав" ХХК		1.0
3	Хөгнө тарнын байгалын цогцолборт газрын хамгаалалтын захиргаа	Зөрчлийн тухай хуулийн 7.17.2	Л.Идэрцогт			0.5
4	Булган аймаг БОГазар	ЗТХуулийн 7.6-р зүйлийн 1 дэх хэсгийн 1.3 дахь заалт	С.Ганбат		0.2	
5	Булган аймаг БОГазар	ЗТХуулийн 7.6-р зүйлийн 1 дэх хэсгийн 1.3 дахь заалт	Б.Сүхбаатар		0.2	
6	Булган аймаг БОГазар	ЗТХуулийн 7.6-р зүйлийн 4 дэх заалт	Ш.Батжамц		0.3	
7	Булган аймаг БОГазар	ЗТХуулийн 7.6-р зүйлийн 1 дэх хэсгийн 1.3 дахь заалт	Д.Бат-Өлзий			0.1
8	Булган аймгийн татварын газар	ТЕХ 84.1, 83.2		Тана-Орд	0.7	
9	Булган аймгийн татварын газар	ТЕХ 83.2, 84.2		Хастав	0.4	
10	Булган аймгийн татварын газар	ТЕХ 82.1.2, 83.2		Ургацхангай	16.4	
11	Булган аймгийн татварын газар	ТЕХ 82.1.2		Бумансүхэс	0.2	
12	Булган аймгийн татварын газар	ТЕХ 83.2, 83.3		Булганмах маркет	2.1	
13	Булган аймгийн татварын газар	ТЕХ 82.1.2		Бор банди агро		4.0
14	Булган аймгийн татварын газар	ТЕХ 82.1.2, 84.1		Хялганат тэмүүлэл		15.8
15	Булган аймгийн татварын газар	ТЕХ 82.1.1, 82.1.2, 84.1,	3196593	Майл уул		1.2
16	Булган аймгийн татварын газар	ТЕХ 82.1.1, 84.1		Өрнөх зол		1.0
17	Булган аймгийн татварын газар	ТЕХ 82.2		Эрдэнэт ус дулаан түгээх сүлжээ		34.8
18	Булган аймгийн татварын газар	Зөрчлийн тухай хуулийн 11.19-8.13		Оргилуун ургац		0.7
19	Санхүүгийн хяналт дотоод аудитын алба	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.6, 13.7, 14.4.2, 14.4.3, 20.2.5, Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хуулийн 4.1, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2021 оны 09 дугаар тогтоолоор баталсан "Ажилгүйдлийн даатгалын сангаас тэтгэмж олгох журам"-ын 5.5, 6.2 дахь заалтуудыг		НДХ	2.5	

“Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт”

20	Санхүүгийн хяналт дотоод аудитын газар	Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр тэтгэмжийн тухай хуулийн 29.2, 6-р зүйл, 4.3.3, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2004 оны 77-р тушаалын хавсралт,		НДХ	1.4	
21	Санхүүгийн хяналт дотоод аудитын газар	Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-дэх заалт		Тэшиг сумын Засаг дарга	10.1	
22	Санхүүгийн хяналт дотоод аудитын газар	Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 12 сарын 25-ны өдрийн 472 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт, Засгийн газрын 2022 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн 194 дүгээр тогтоол зөрчсөн цалинг дутуу олгосон		Хангал сумын ЗДТГ	0.3	
23	Санхүүгийн хяналт дотоод аудитын газар	Хөдөлмөрийн тухай хуулийн 107.1 дэх , 109.6. дахь заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6 дахь заалт		Баяннуур сум ЗДТГ	0.1	
24	Санхүүгийн хяналт дотоод аудитын газар	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.6, 13.7 заалтууд		Булган сум Ерөнхий боловсролын 1-р сургууль	0.1	
25	Санхүүгийн хяналт дотоод аудитын газар	Төсвийн тухай хуулийн 16.5.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1, 13.5, 13.6, Сангийн сайдын 2012.12.21-ны 276 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам"-ын 2.6, 2.7, 3.1, 3.2 дахь заалтуудыг		Хангал сумын Хялганат тосгоны Соёлын төв		0.1
26	Санхүүгийн хяналт дотоод аудитын газар	Төсвийн тухай хуулийн 16.5.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1, 13.5, 13.6, Сангийн сайдын 2012.12.21-ны 276 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам"-ын 2.6, 2.7, 3.1, 3.2 дахь заалтуудыг		Хангал сумын Хялганат тосгоны Соёлын төв		0.2
27	Санхүүгийн хяналт дотоод аудитын газар	Төсвийн тухай хуулийн 16.5.5, 41.2.2, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.5, 13.6, Хөдөлмөрийн тухай хуулийн 101.1, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/192 дугаар тушаалаар баталсан "Дундаж цалин хөлс тодорхойлох журам"-ын 1.4.5 дахь заалтуудыг		Хангал сумын Хялганат тосгоны Соёлын төв		0.1

“Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт”

28	Санхүүгийн хяналт дотоод аудитын газар	Төсвийн тухай хуулийн 16.5.5, 41.2.2, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1, 13.5, 13.6, 13.7, 18.1, Сангийн сайдын 2012.12.21-ны 276 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам"-ын 2.6, 2.7, 3.1, 3.2 дахь заалтуудыг		Хангал сумын Хялганат тосгоны Соёлын төв		3.6
29	Санхүүгийн хяналт дотоод аудитын газар	Төсвийн тухай хуулийн 16.5.5, 41.2.2, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1, 13.5, 13.6, 13.7, 18.1, 20.1.4, 20.2.5, 20.2.6, 20.2.9, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягыг нөхөх заавар"-ын НХМаягт МХ-4 заалтуудыг		Хангал сумын Хялганат тосгоны Соёлын төв		0.9
30	Санхүүгийн хяналт дотоод аудитын газар	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1, 13.5, 13.6, 14.4.3, 20.2.5, 20.2.6, 20.2.9, аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2014.01.23-ны өдрийн 17 дугаар тогтоолоор баталсан "Орон нутгийн өмчит хуулийн этгээд нь ... Хуульд заасан бүхий л эх үүсвэрийн хүрээнд олж авсан үндсэн хөрөнгийг тухай бүрд нь Өмчийн албанд бичгээр мэдэгдэж, хянуулсаны дараа байгууллагын үндсэн хөрөнгийн бүртгэлд бүртгэнэ" заасныг		Хангал сумын Хялганат тосгоны Соёлын төв		0.05
31	Санхүүгийн хяналт дотоод аудитын газар	Хутаг-Өндөр сумын ИТХ-ын Х дугаар хуралдааны 9 дүгээр тогтоолын 3.1 дэх заалт зөрчсөн		Хутаг-Өндөр сум Илчит -Хутаг ОНӨХХК		0.6
32	Санхүүгийн хяналт дотоод аудитын газар	Монгол Улсын автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 2./Аж ахуйн нэгж, байгууллага автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн жилийн албан татварыг тэнцүү хэмжээгээр улирал бүрийн сүүлчийн сарын 25-ны дотор багтаан төсөвт төлж дараа оны 2 дугаар сарын 15-ны дотор тайланг татварын албанд ирүүлнэ./ заалтыг		Хутаг-Өндөр сумын Сум дундын ойн анги		0.3
33	Санхүүгийн хяналт дотоод аудитын газар	Төсвийн тухай хуулийн 16.5.5, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт, Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журмын 2.7 дахь заалт		Орхон сумын ЭМТөв		1.6

“Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт”

34	Санхүүгийн хяналт дотоод аудитын газар	Төсвийн тухай хуулийн 16.5.5, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт, Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журмын 2.7 дахь заалт		Орхон сумын ЭМТөв		0.4
35	Санхүүгийн хяналт дотоод аудитын газар	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7 дахь заалт		Орхон сумын ЭМТөв		0.1
36	Санхүүгийн хяналт дотоод аудитын газар	Хөдөлмөрийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1.3 /гүйцэтгэсэн ажил үүрэгтээ тохирсон цалин хөлс авах;/ заалт, 110 дугаар зүйлийн 110.1./Ээлжийн амралтын цалинг ажилтны тухайн ажлын жилийн дундаж цалин хөлснөөс тооцож олгоно./ заалтуудыг		Орхон сумын ЗДТГ		0.5
37	Санхүүгийн хяналт дотоод аудитын газар	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4, 14.4.2, 20.2.6 дахь заалтыг		ХААИС-ийн харъяа Булган аймаг дахь Политехникийн коллеж		6.5
38	Санхүүгийн хяналт дотоод аудитын газар	Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолын хавсралт 2.4 дэх заалтыг		Сайхан сумын ЗДТГ		0.05
39	Санхүүгийн хяналт дотоод аудитын газар	Төсвийн тухай хуулийн 16.5.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.5, 13.6, 13.7, 14.4.2, 20.1.4, 20.2.5 дахь заалтууд		Сайхан сумын Соёлын төв		0.1
40	Санхүүгийн хяналт дотоод аудитын газар	Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам”-ын 2.6-д /Төсвийн байгууллага үндсэн болон туслах үйл ажиллагаа (бусад орлого)-наас орох орлогыг мөнгөн касстаа бэлнээр хүлээн авч энэхүү орлогыг/ түүнийг шууд захиран зарцуулах эрхгүй / ажлын дараагийн өдөрт багтаан кассын нярав Төрийн сан дахь бүртгэлийн дансанд тушаана./ заасныг зөрчсөн		ХХААГ /Алтаргана-2024/		3.3

“Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт”

41	Санхүүгийн хяналт дотоод аудитын газар	Тендер шалгаруулалтын БУАХААГ/20240202087/ дугаартай аймгийн ЗДТГ-ын төвлөрсөн арга хэмжээнд ашиглагдах асар, майхан нийлүүлэх нийлүүлэгчийг сонгон шалгаруулах баримт бичгийн тусгай нөхцөлийн ГЕН 4.17-д /Алдангийн хувь: Хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.5 хувь байна. Нийт алдангийн хувь гүйцэтгээгүй үүргийн 10 хувиас хэтрэхгүй байна./, Аймгийн Засаг даргын 2024.06.12-ны А/436 дугаар захирамжийн хавсралт /Хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.5 хувь байна. Нийт алдангийн хувь гүйцэтгээгүй үүргийн 10 хувиас хэтрэхгүй байна./ заасныг зөрчсөн байна.		Аймгийн ЗДТГ /Алтаргана-2024/		1.5
42	Аймгийн ЗДТГ	Холбогдох зөвшөөрөлгүйгээр түгээмэл тархацтай ашигт малтмал олборлосон Зөрчлийн тухай хуулийн 7.12-1.2.		Орхон Азза ТӨХК	2.2	
43	Аймгийн ЗДТГ	Зөрчлийн тухай хуулийн 7.11-2.1.		Тэргүүн майнинг ХХК	10.0	
44	Аймгийн ЗДТГ	Зөрчлийн тухай хуулийн 7.11-2.1.		Бүрдэл майнинг ХХК	10.0	
45	Аймгийн ЗДТГ	Зөрчлийн тухай хуулийн 7.11-2.2.		Тамсаг баялаг ХХК		10.0
46	Аймгийн ЗДТГ	Зөрчлийн тухай хуулийн 7.11-2.2.		Төсөлч ХХК		7.0
47	Аймгийн ЗДТГ	Зөрчлийн тухай хуулийн 7.11-2.1		Төсөлч ХХК		10.0
48	ЗДТГ-ын санхүү, төрийн сангийн хэлтэс	Булган аймаг, Хишиг-Өндөр сумын 5 дугаар баг, Мааньт 16-14 гудамж, 5 тоотод оршин суух, 88976049 утасны дугаартай "Дөшхангай уул" ХХК-ийн захирал Төмөр-Очир овогтой Сүнжидмаа нь 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаа хуулиар тогтоосон хугацаанд харилцагч санхүүгийн хэлтэст цахим хэлбэрээр хүргүүлэх үүргээ биелүүлээгүй зөрчил үйлдсэн.		Дөшхангай уул ХХК	2.0	
49	ЗДТГ-ын санхүү, төрийн сангийн хэлтэс	Ш.Алтанчмэг нь сонгуулийн зардлын тайлангаа хуульд заасан хугацаанд ирүүлээгүй.	Ш.Алтанчмэг		10.0	

“Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт”

50	ЗДТГ-ын санхүү, төрийн сангийн хэлтэс	Н.Мөнхцэцэг нь сонгуулийн зардлын тайлангаа хуульд заасан хугацаанд Төрийн аудитын гээрт хүргүүлээгүй.	Н.Мөнхцэцэг		10.0	
51	Зэд Хантай Бүтээлийн нурууны дархан цаазат газрын хамгаалалтын захиргаа	Зөрчлийн тухай хуулийн 7.7.1.1, Байгалийн ургамлын тухай хууль зөрчсөн	Г.Мэндбат		0.1	
52	Зэд Хантай Бүтээлийн нурууны дархан цаазат газрын хамгаалалтын захиргаа	Зөрчлийн тухай хуулийн 7.7.1.1, Байгалийн ургамлын тухай хууль зөрчсөн	Ц.Өлзийбаатар		0.1	
53	Зэд Хантай Бүтээлийн нурууны дархан цаазат газрын хамгаалалтын захиргаа	Зөрчлийн тухай хуулийн 7.7.1.1, Байгалийн ургамлын тухай хууль зөрчсөн	Д.Лхагвадорж		0.1	
54	Зэд Хантай Бүтээлийн нурууны дархан цаазат газрын хамгаалалтын захиргаа	Зөрчлийн тухай хуулийн 7.7.1.1, Байгалийн ургамлын тухай хууль зөрчсөн	А.Баясгалан		0.1	
55	Зэд Хантай Бүтээлийн нурууны дархан цаазат газрын хамгаалалтын захиргаа	Зөрчлийн тухай хуулийн 7.7.1.1, Байгалийн ургамлын тухай хууль зөрчсөн	А.Алтанхүү		0.1	
56	Зэд Хантай Бүтээлийн нурууны дархан цаазат газрын хамгаалалтын захиргаа	Зөрчлийн тухай хуулийн 7.7.1.1, Байгалийн ургамлын тухай хууль зөрчсөн	Г.Баатар-Эрдэнэ		0.1	
57	Булган аймгийн Цагдаагийн газар	Бэлэн бус торгуулийн орлогын үлдэгдэл			194.0	332.2
58	Булган аймгийн Цагдаагийн газар	Шийтгэврийн торгуулийн үлдэгдэл			12.9	93.7
Нийт дүн					286.9	532.3

Хавсралт №3

Аймаг, сумдын 2023, 2024 онуудад торгуулийн орлогын гүйцэтгэлээс ГХУСАС3-ийн зардлын хуваарилалтын жагсаалт

“Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт”

/сая.төг/

№	Сумдын нэрс	Аймаг сумдын ГХУСАСЗ-ийн зардлын хуваарилалт							
		2023 он				2024 он			
		Аймгийн баталсан дүн	Сумын баталсан дүн	40 хувиар хувиарлах тоо	Илүү, дутуу	Аймгийн баталсан дүн	Сумын баталсан дүн	40 хувиар хувиарлах тоо	Илүү, дутуу
1	Булган	280	62.0	112.0	(50.0)	333.0	190.0	133.2	56.8
2	Бугат	22.0	7.0	8.8	(1.8)	36.0	7.0	2.8	4.2
3	Баян-Агт	12.0	-	4.8	(4.8)	12.0	4.0	1.6	2.4
4	Баяннуур	83.0	10.0	33.2	(23.2)	83.0	5.0	2.0	3.0
5	Бүрэгхангай	45.0	17.2	18.0	(0.8)	71.0	16.0	6.4	9.6
6	Дашинчилэн	20.0	6.4	8.0	(1.6)	30.0	6.0	2.4	3.6
7	Гурванбулаг	10.0	4.0	4.0	-	10.0	4.0	1.6	2.4
8	Могод	10.0	1.8	4.0	(2.2)	10.0	2.5	1.0	1.5
9	Рашаант	210.0	50.0	84.0	(34.0)	538.1	87.0	34.8	52.2
10	Сайхан	9.0	2.0	3.6	(1.6)	9.0	3.6	1.4	2.2
11	Хутаг-Өндөр	80.0	20.0	32.0	(12.0)	130.0	30.0	12.0	18.0
12	Хишиг-Өндөр	12.0	2.2	4.8	(2.6)	21.5	4.0	1.6	2.4
13	Тэшиг	12.0	4.8	4.8	-	12.0	6.0	2.4	3.6
14	Сэлэнгэ	23.8	2.0	9.5	(7.5)	28.7	4.8	1.9	2.9
15	Орхон	41.0	6.4	16.4	(10.0)	36.0	8.0	3.2	4.8
16	Хангал	40.4	8.8	16.2	(7.4)	55.4	13.0	5.2	7.8
17	Хялганат	25.0	12.0	10.0	2.0	53.0	13.2	5.3	7.9
18	Аймгийн ИТХ	151.2	120.0	60.5	59.5	69.7	126.0	50.4	75.6
Нийт дүн		1,086.4	336.6	434.6	(98.0)	1,538.4	530.1	269.2	260.9

Хавсралт №4

Аймаг, сумдын 2023, 2024 онуудад ГХУСАСЗ-ын зардлын гүйцэтгэл

/сая.төг/

№	Сумдын нэрс	2023 он			2024 он			Тоног төхөөрөмжийн зарцуулалт			
		Зардал баталсан дүн	Гүйцэтгэл	Илүү, дутуу	Зардал баталсан дүн	Гүйцэтгэл	Илүү, дутуу	2023 он	хувь	2024 он	хувь
1	Булган	62.0	59.1	2.9	189.9	189.9	-	28.2	0.5	98.5	0.5
2	Бугат	7.0	6.9	0.1	7.0	7.0	-	4.3	0.6	3.9	0.6

“Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт”

3	Баян-Агт	-	-	-	4.0	4.0	-	0	-	2.4	0.6
4	Баяннуур	10.0	9.8	0.2	5.0	4.9	0.1	4.3	0.4	1.0	0.2
5	Бүрэгхангай	17.2	13.4	3.8	16.0	14.5	1.5	0	-	0	-
6	Дашинчилэн	6.4	6.4	-	6.0	6.0	-	5.4	0.8	5.0	0.8
7	Гурванбулаг	4.0	3.8	0.2	4.0	3.9	0.1	0	-	1.1	0.3
8	Могод	1.8	1.8	-	2.5	2.3	0.2	0	-	1.0	0.4
9	Рашаант	50.0	50.0	-	87.0	87.0	-	17.5	0.4	60.0	0.7
10	Сайхан	2.0	1.4	0.6	3.6	3.6	-	0	-	0	-
11	Хутаг-Өндөр	20.0	20.0	-	30.0	30.0	-	3.1	0.2	11.9	0.4
12	Хишиг-Өндөр	2.2	1.7	0.5	4.0	4.0	-	0	-	0.5	0.1
13	Тэшиг	4.8	4.8	-	6.0	12.0	(6.0)	0.8	0.2	0	-
14	Сэлэнгэ	2.0	2.0	-	4.8	4.8	-	0.01	0.0	0	-
15	Орхон	6.4	6.1	0.3	8.0	8.0	-	1.8	0.3	7.0	0.9
16	Хангал	8.8	8.7	0.1	13.0	13.0	-	5.5	0.6	7.1	0.5
17	Хялганат	12.0	12.0	-	13.2	13.2	-	1.1	0.1	0.6	0.0
18	Аймгийн ИТХ	120.0	119.9	0.1	126.0	125.6	0.4	12.6	0.1	15.9	0.1
	Нийт дүн	336.6	327.8	8.8	530.0	533.7	(3.7)	84.6	0.3	215.9	0.4